



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ОРХОН АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2017 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 02

Эрдэнэт

Г Тайлан баталгаажуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Монгол улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тушаал, Гүйцэтгэлийн аудитын журмын 12 дугаар зүйлийн 12.40, Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журмын 4.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. МУЕА-ын 2017 оны А/12 тоот тушаал, ҮАГ-ын нэгдсэн удирдамж, байгууллагын 2017 оны бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийгдсэн "Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг" гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, зөрчлийн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газар, Хотын захирагчийн алба, Орон нутгийн өмчийн газар, Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨҮГ-т хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын биелэлтэд хяналт тавин ажиллахыг аудитын менежер /Б.Эрдэнэ/, гүйцэтгэлийн аудитын ахлах аудитор /Б.Байгал/, шинжээч /Т.Болормаа/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

070002



**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН
ГАЗРЫН ХАРЬЯА ОРХОН АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

**“Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга
хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”**

**Хөрөнгө оруулалтын төлөвлөлт оновчгүй, техникийн ерөнхий
шийдэл, зураг төслийн даалгавар, захиалагчийн хяналт хангалтгүй
хийгдсэнээс үр ашиггүй, чанаргүй, үр дүн тодорхойгүй хөрөнгийн
тоо өссөн байна.**

**Орхон аймаг
2017 он**

	АГУУЛГА	
Аудитын тайлан бэлтгэсэн Орхон аймгийн Аудитын газар Дарга:	Ц.Нармандах	Товчилсон үгийн тайлбар
Аудитын менежер:	Б.Эрдэнэ	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, стандартын талаарх мэдэгдэл
Ахлах аудитор:	Б.Байгал	Бүлэг 1: Хөрөнгө оруулалтын ТАХ нь Засаг даргын мөрийн хөтөлбөртэй уялдсан хэдий боловч хэрэгцээ шаардлагагүй, техникийн нөхцөл иж бүрэн бус, үр ашиггүй хөрөнгө төлөвлөж баталсан байна.
Шинжээч:	Т.Болормаа	1.1 ТАХ-үүд нь аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдсан байна.
2017 оны 03 дугаар сар		1.2 Хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлоогүй, үр ашиггүй хөрөнгө оруулалтын ТАХ төлөвлөж хөрөнгө зарцуулсаар байна.
Уг тайланг Орхон аймгийн		1.3 Техникийн нөхцөлийн иж бүрэн байдал хангалтгүй байхад зураг төсөл хийгдсэн байна.
Аудитын газрын цахим хуудаснаас үзнэ үү.		1.4 ТАХ-ний ТЭЗҮ, зураг төсөл иж бүрэн, дэвшилтэт технологиор хийгдсэн эсэхийг хянаж, ИТХ-аар батлахдаа бөөн дүнгээр батлахгүй байх шаардлагатай байна.
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, лавлах зүйл байвал 70357955 Дугаарын утас, 70359826 дугаарын факсаар Харилцана уу.		1.5 Болзошгүй аваарын зардлаас хөрөнгө зарцуулахдаа ОБГ, МХГ-ын дүгнэлт гараагүй ТАХ-нд хөрөнгө зарцуулсан байна
Хаяг: Орхон аймгийн Аудитын газар Баян-өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон		1.6 Хөрөнгө оруулалтаар хийгдэх ТАХ-ний онцлог байдлыг харгалзан үзэж гүйцэтгэх хугацааг улиралын байдалтай зохицуулж байх шаардлагатай байна.
		1.7 Шилжих үлдэгдлээс 4005.8 сая төгрөгийн 71 ТАХ хэрэгжихээр батлагдсан байна.
		Бүлэг 2 Гүйцэтгэгчид нэг ижил хугацаанд 2 ба түүнээс дээш ажил гүйцэтгүүлж зарим ажил чанаргүй болсон, тендерт оролцогчийн талаарх мэдээллийн сан хангалтгүй байна.
		2.1 Үнэлгээний хороог журмын дагуу зохион байгуулж, худалдан авах ажиллагааны ил тод, байдлыг хангасан байна.
		2.2 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа нэг ижил цаг хугацаанд 2 ба түүнээс дээш ажил олгож гүйцэтгүүлсэнээр зарим ажил чанаргүй хийгдсэн байна.
		2.3 Худалдан авах ажиллагааг зохион байгуулж, тайлагнасан хэдий ч тендер оролцогч байгууллагын талаарх мэдээллийн сан хангалтгүй байна.
		2.4 Худалдан авах ажиллагаанаас бий болсон төсвийн хэмнэлтийг ерөнхий орлогын данс руу бүрэн төвлөрүүлээгүй нь Сангийн яамнаас эрх нээхдээ дутуу нээсэнтэй холбоотой байна.
		2.5 Худалдан авах ажиллагааны эрх шилжүүлсэн ТАХ орон нутагт байхгүй байна.
		2.6 ТАХ-ний зориулалтыг ИТХ-ын тогтоолын дагуу өөрчилсөн, тоног төхөөрөмж нэрийн дор авто машин худалдан авч УИХ-ын тогтоолыг зөрчсөн байна.
		Бүлэг 3 Гүйцэтгэгчтэй байгуулсан хэлцлийн гэрээний зарим зүйл заалт тодорхойгүй, зохиогч ба захиалагчийн хяналт хангалтгүй хэрэгжүүлсэн байна.
		3.1 Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний зарим зүйл заалт тодорхойгүй, оновчтой бус байна.
		3.2 Хөрөнгө оруулалтын ажил нь төлөвлөлт оновчгүй, ашиглагч байгууллагаас шалтгаалан зориулалт бус зарцуулагдсан байна.
		3.3 Хөрөнгө оруулалтаар хийгдсэн ТАХ-ны гүйцэтгэл бүрэн хангагдаагүй байхад санхүүжилт олгосон байна.
		3.4 Томоохон барилга байгууламжийн төсөв хийхдээ нэгдсэн төсөв хийж түүнийгээ хэсэгчлэн жижиглээгүйгээс

ажлын тоо хэмжээ давхцах, хийгдсэн ажил дараагийн төсөвт орох эрсдэл үүссэн байна.	
3.5 ТАХ-ний хэрэгжилтэд зохиогчийн болон захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэнээс чанаргүй ажлын тоо өссөн байна.	27-28
3.6 Хэрэгжиж дууссан ТАХ-г улсын комисс хүлээж аваагүй, улсын комиссын акт гараагүй байхад санхүүжилт олгож ашиглалтад оруулсан ТАХ байхгүй байна.	28
3.7 Хөрөнгө оруулалтын ТАХ-ний үр дүн тодорхойгүй, чанарын доголдолтой ТАХ нэмэгдсээр байна.	29-30
Дүгнэлт, зөвлөмж	
Алдаа зөрчлийн нэгтгэл	

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХББЗА	Хот байгуулалт барилга захиалагчийн алба
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
УИХ	Улсын их хурал
ТБОНӨХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил
БАҮХАТ	үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТАХ	Төсөл арга хэмжээ
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СӨХ	Сууц өмчлөгчдийн холбоо
БОЭТ	Бүсийн оношлогоо эмчилгээний төв
ДТС	Дулаан түгээх сүлжээ
ХК	Хувьцаат компани
ЭБЦТС	Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
МУ	Монгол улсын
УДДТ	Ус дулаан дамжуулах төв
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ХА	Харьцуулалтын арга
ШХА	Шууд худалдан авалт Монгол улсын

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл:

1. **Аудит хийх үндэслэл:** Монгол улсын ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд “ Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” сэдэвт гүйцэтгэлийн аудит хийж гүйцэтгэлээ.
2. **Аудитын зорилт:** Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашигт аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:
 - Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх
 - Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр Хөгжлийн банкнаас 2016 онд санхүүжсэн төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх
 - Векселиэр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх
 - Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх
3. **Аудитын хамрах хүрээ:** Аудитаар аймгийн ЗДТГ, Хөгжлийн бодлогын хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн алба, ХББЗА ОНӨҮГ, ГХБХБГ, Баян-өндөр Жаргалант сумдууд, ашиглагч, гүйцэтгэгч байгууллагуудын хүрээнд аудит хийлээ.
4. **Аудитын арга зүй:** Аудитыг гүйцэтгэхдээ ТХШС, удирдамж (АДБОУС 3000-3100) гүйцэтгэлийн аудитын журмын хүрээнд ГХБХБГ, ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн алба бусад холбогдох байгууллагуудын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа тодруулга авах, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулан, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулж ажиллаа.
5. **Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:** Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамжид заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйл, холбогдох тайлан, мэдээ, судалгааг, аудитын ажлын баримтад хавсаргав. Аудитад дараах хууль эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:
 - Монгол улсын 2016 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт
 - Төсвийн тухай хууль
 - Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
 - Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
 - ТБОНӨХБАҮХАТХууль
 - Барилгын тухай хууль
 - Иргэний хууль
 - Концессын тухай хууль

- Дээрх хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газар, Аймаг сумын ИТХ-ын тогтоол,
- Сангийн сайдын 2012 он 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”

- 6. Аудит хийх бүрэлдэхүүн:** Аудитыг Орхон аймгийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, аудитын менежер Б. Эрдэнэ чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Байгал, шинжээч Б.Болормаа нар гүйцэтгэлээ.
- 7. Аудитын тайлан, баталгаажуулалт:** Аудитыг 2017 оны 3 сарын 2-ны өдрөөс 4 дүгээр сарын 15-ны хооронд хийж гүйцэтгэн холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүллээ.

Ерөнхий мэдээлэл

Орон нутгийн төсвөөс 2016 онд 393 төрлийн 24714.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг хийхээр төлөвлөж ИТХ-аар баталсан.

Аймгийн ИТХ орон нутгийн хөрөнгө оруулалтыг 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 05 дугаар тогтоолоор 8064.4 сая төгрөгөөр баталсан.

Төсвийн тодотголоор 2016 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит 6 дугаар хуралдаанаар шилжих үлдэгдлээс хийгдэх хөрөнгө оруулалтыг 16949.8 сая төгрөгөөр нэмсэн бол 2016 оны 08 сарын 17-ны өдрийн 11 дүгээр худалдаанаар орон нутгийн хөрөнгө оруулалтыг 3155.8 сая төгрөгөөр нэмж, орон нутгийн шилжих үлдэгдлээр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудаас 4728.7 сая төгрөгийг хасаж баталсан байна.

Авто замын сангийн хөрөнгөөр нийт 8 ажилд 637.1 сая төгрөг, Эрдэнэт сангийн хөрөнгөөр 4 ажилд 56.6 сая төгрөг, Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 26 ажилд 679.5 сая төгрөг зарцуулахаар тогтоолд тусгагдсан.

Харин улсын төсвийн санхүүжилтээр аймагт эрх шилжиж ирсэн ажил байхгүй. Ахмадын ордны барилгын баталгааны 5% болон магадлашгүй ажлын санхүүжилт 50.3 сая төгрөг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамнаас шилжин ирсэнийг гүйцэтгэгч байгууллагад шилжүүлсэн байна.

ГХБХБГ Барилгын хөгжлийн төвтэй хийсэн гэрээний дагуу захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн 9 төсөл арга хэмжээ байгаа бөгөөд хяналт хэрэгжүүлсэн тайлан мэдээг барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн байна.

Өмнөх онд хийгдсэн гүйцэтгэлийн аудитын дүнгээр 15 зөвлөмж, 138.4 сая төгрөгийн 8 албан шаардлага, 26.7 сая төгрөгийн 1 төлбөрийн актыг холбогдох байгууллага албан тушаалтанд хариуцуулан өгөгдсөн бөгөөд тэдгээрийн биелэлтийг хүснэгтээр харуулбал:

Төлбөрийн акт				
№	Утга	Дүн	Хариуцах эзэн	Биелэлт
1	2014 онд үүссэн “Урагшлах” ХХК-наас авах авлага 300000,0 мянган төгрөгөөс 2015 онд 273288,1 мянган төгрөгийг суутган авч 26711,9 мянган төгрөгийг дутуу суутгасан, орон нутгийн нэгдсэн санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй	26711.9	СТСХ	2016.05.03-нд Төрийн сангийн 210000955 тоот дансанд төлсөн
Албан шаардлага				
	Аймгийн бүсийн оншилгоо эмчилгээний төвд 80000,0 мянган төгрөгөөр худалдан авсан зөөврийн 2 ширхэг рентген			

1	аппаратад Ашиглагч байгууллагаас туршилт тохируулга хийгдсэн, хөрөнгөндөө бүртгэсэн эсэх баримтыг харгалзан үзэлгүйгээр нийлүүлэгч Дашдэлжээ ХХК-д санхүүжилтыг бүрэн олгосон	80000.0	Санхүү төрийн сангийн хэлтэст	Уг аппаратыг ашиглаж байгаа
2	Урьдчилсан гүйцэтгэл гаргаж 4588,4 мянган төгрөг олгуулсан, 21690,6 мянган төгрөгийн ажил хяналт муу хийсэн өмнөх аудитаар өгсөн алдааг давтан гаргасан	26,279.0	ХББЗА ОНӨҮГ	Зөрчил давтан гарсан
3	Орон нутгийн Хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн Эрх бүжинхэн цэцэрлэгийн 348562,3 мянган төгрөгийн гэрээний дүнтэй барилгын их засварын ажлын чанаргүй гүйцэтгэсэн	5,881.5	"ЭТНАНО" ХХК	Чанаргүй гүйцэтгэсэн ажлыг дахин хийсэн
4	Орон нутгийн Хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн Худалдааны гудамжны гадна зам талбайн тохижилтын 292000,8 мянган төгрөгийн гэрээний дүнтэй засварын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн, 1368,2 мянган төгрөгийн улиралын чанартай ажлыг банкны баталгаагүйгээр урьдчилан авсан	1,368.2	"Хөрөнгийн бэл" ХХК	Дахин гүйцэтгэсэн боловч ашиглалт байхгүй
5	Орон нутгийн Хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн Жаргалант сумын Арцадын давааг засварлах 69226,3 мянган төгрөгийн зам засварын ажлын санхүүжилтаас 3220,2 мянган төгрөгийн улиралын чанартай ажлыг банкны баталгаагүйгээр урьдчилан авсан	3,220.2	"Жавхлант харгуй" ХХК	Биелэлтийг баримтаар ирүүлсэн 2017 онд газар дээр нь шалгах
6	Орон нутгийн Хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн 5 дугаар цэцэрлэгийн 39860,0 мянган төгрөгийн барилгын их засварын ажлаас 178,9 мянган төгрөгийн ажлыг чанаргүй гүйцэтгэсэн	178.9	"Ричи Ойл" ХХК	Чанаргүй ажлыг зассан
7	Орон нутгийн Хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн Унага цэцэрлэгийн их засварын ажил 719517,1 мянган төгрөгийн барилгын их засварын ажлаас 20663,3 мянган төгрөгийн ажлыг чанаргүй гүйцэтгэсэн	20,663.3	"Урагшлах" ХХК	Чанаргүй ажлыг зассан
8	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн 5 дугаар цэцэрлэгийн 69700,0 мянган төгрөгийн барилгын их засварын ажлаас 848,5 мянган төгрөгийн ажлыг чанаргүй гүйцэтгэсэн	848.5	"Танан гранд" ХХК	Чанаргүй ажлыг зассан

Зөвлөмж

1	Хөрөнгө оруулалтын ажлуудыг хурлаар баталгаажуулахаас өмнө ажил бүрийн санхүүжилтийн дүн түүний судалгаа хийгдсэн баримттай урьдчилан танилцах, шинээр баригдах барилгын зураг төсөв, техник хяналтын талаар хуульд заасан хэмжээнд хяналт хийж, батлах.		Аймгийн ИТХ	Биелэсэн
2	Аймгийн ЗДТГ- с өргөн барьж байгаа хөрөнгө оруулалтын төсвийг хянах боломжтой цаг хугацааг тогтоон мөрдүүлэх, барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээний төсвийг нэг дүгээр улиралд багтаан баталж байх.			Хангалтгүй
3	Аудитын дүнгээр гарсан алдаа зөрчлийн талаар манай байгууллагаас хүргүүлсэн албан бичигт тусгагдсан зөвлөгөөг хэрэгжүүлэх талаар бодиттой ажил төлөвлөж гүйцэтгэлийг хянах		Аймгийн Засаг дарга	Биелэсэн
4	Барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх боломж бүрдүүлэх		Аймгийн ЗДТГ	Биелэсэн
5	Төсөв зохиоход шаардлагатай материалын нэгжийн өртгийг үнийн өсөлттэй уялдуулан тогтоож нэгдсэн журмаар баталж мөрдөх			Биелэсэн
6	Дотоод хяналт аудитын албатай хамтарч ажиллаж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.			Хангалтгүй
7	Төсөвтэй хэдий ч зураггүй хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөгөөнд тусгуулах, батлуулах, худалдан авалт хийлгэхийг зогсоох гүйцэтгэсэн зураг болон төсвийн өмнөх тайлбар бичигт гүйцэтгэсэн он сар өдөр, зураг төсөв хийх шийдвэрийн дугаар шийдвэр гаргагчийн нэрийг тодорхой тусгаж байх		ХББЗА	Биелэсэн
8	Зураг төсөв зохиоходоо газар дээр нь очиж хэмжилт хийсэн эсэх, ажил гүйцэтгэх талбайн бэлтгэл ажил бүрэн хийгдсэн эсэхэд хяналт тавих			Хангалтгүй
9	Өмнөх онд гүйцэтгэсэн гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ашиглалт, хэрэглэгчтэй холбох талаар бодитой тооцоо, судалгаа гэрээ хэлцэл, шийдвэр гаргах талаар тодорхой ажил зохиож үр дүнг тооцох.			Ажил эхлүүлсэн байна
10	Тендерт оролцогч нэг этгээдэд нэгээс дээш багц бараа, ажил, үйлчилгээгээр гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсэн бол энэ тухай худалдан авах ажиллагааны тайланд мэдээлэлд тусгаж байх		Худалдан авах ажиллагааны алба	Биелэсэн
11	Тусгай зориулалтын тоног төхөөрөмжийн худалдан авах тендерийн тодорхойлолтод тоног төхөөрөмжийг туршилтаар тодорхой хоногт ажиллуулан шалгах тухай тодотгон оруулж өгөх			Биелэсэн

12	Хөрөнгө оруулалтын ажлуудын том жижигээс хамаарахгүйгээр бүх ажлыг зураггүй хяналтын төсвөөр тендер зарлахгүй байх,		Биелэсэн
13	Хөрөнгөө санхүүгийн бүртгэлдээ тусгаагүй байгууллагуудад уг хөрөнгийг материалыг хүргүүлэх, бүртгэлд тусгасан эсэхийг хянаж баталгаажуулах	Өмчийн харилцааны газарт	Зөрчил давтагдсан
14	Тусгай зориулалтын, нарийн мэргэжлийн оношилгоо, дүрс бичлэгийн тоног төхөөрөмжүүдийг хөрөнгөнд бүртгэхдээ туршилт, тохируулга хийсэн баримтыг хавсаргаж, тухай бүрд нь хөрөнгөнд бүртгүүлэх албан бичгийг ашиглагч байгууллагад хүргүүлж байх		Хангалтгүй
15	Санхүүжилтыг олгохдоо худалдан авсан барилга байшингийн хувьд хөрөнгийн үнэлгээний тайлан, МХГ- ийн дүгнэлтийг авч байх, бусад тоног төхөөрөмжид ашиглагч байгууллагын албан бичиг, туршилтын хугацаанд ажилуулсан баримтыг төлбөр төлсөн баримтанд хавсаргаж байх	СТСХ	Биелэсэн

Аудитын дүнгээр хүргүүлсэн 1 төлбөрийн акт хүү торгуулийн дансанд бүрэн төлөгдсөн, 138.4 сая төгрөгийн 8 албан шаардлагаас ХББЗА ОНӨҮГ-т хүргүүлсэн 26.3 сая төгрөгийн 1 албан шаардлагын хэрэгжилтийг хангалтгүй зөрчил дахин давтагдсан.

Төрийн аудитын тухай хуулийн 28.2. “Дараах тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” 28.2.2. “төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд” гэж заасны дагуу ажил хариуцсан ажилтнуудад хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх шаардлагатай байсан боловч ажилтнууд өөрчлөгдсөн тул ажлын хариуцлага сахилга батыг сайжруулах албан шаардлагыг дахин хүргүүлсэн.

Өмнөх аудитаар 15 зөвлөмжөөс Аймгийн ИТХ, ЗДТГ, ХББЗА ОНӨҮГ, Орон нутгийн өмчийн газарт хүргэгдсэн 4 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Хэрэгжилт хангалтгүй 4 зөвлөмжөөс Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн 2 зөвлөмж хэрэгжээгүй зөрчил давтагдсан байх тул тус байгууллагад зөрчил арилгах албан шаардлага хүргүүлж, Аймгийн ИТХ болон ЗДТГ-т 2 зөвлөмжийг давтан зөвлөмж хэлбэрээр хүргүүлэв.

Хэрэгжилт хангалтгүй албан шаардлага зөвлөмжийг 2017 онд хийгдсэн аудитын тайланд алдаа зөрчлөөр тусгасан болно.

Бүлэг 1: Хөрөнгө оруулалтын ТАХ нь Засаг даргын мөрийн хөтөлбөртэй уялдсан хэдий боловч хэрэгцээ шаардлагагүй, техникийн нөхцөл иж бүрэн бус, үр ашиггүй хөрөнгө төлөвлөж баталсан байна.

1.1 ТАХ-үүд нь аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдсан байна.

Энэ онд аймгийн ИТХ хөрөнгө оруулалтыг 3 удаа тодотгон баталсан. Үүнээс 2016 оны 10 дугаар сарын 28-нд хийгдсэн хуралдаанаар орон нутгийн хөрөнгө оруулалтыг 11220.2 сая төгрөг, шилжих үлдэгдлийг 12221.2 сая төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг нийт 23441.4 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийг тодотгон 10 дугаар сард батлахдаа барилгын их засварын 89 ажилд 10169.2 сая төгрөг, инженерийн шугам сүлжээний 43 ажилд 5856.2 сая төгрөг, авто замын засвар шинэчлэлийн 8 ажилд 1247.2 сая төгрөг, цахилгаан эрчим хүчний 18 ажилд 2029.4 сая төгрөг, тус тус баталсан.

Харин Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 26 ТАХ-нд 679.5 сая төгрөг, Замын сангийн хөрөнгөөр 8 ТАХ-нд 637.1 сая төгрөг, Эрдэнэт сангийн хөрөнгөөр 4 ТАХ-нд 56.6 сая төгрөг зарцуулахаар батлагдсан байна.

Хөрөнгө оруулалтын батлагдсан дүнг 2015 онтой харьцуулахад 4.6 хувиар өссөн байна. Дэлгэрэнгүйг хүснэгтээр харуулбал:

Д/д	Ажлын төрөл	2015 онд батлагдсан ажил		2016 онд батлагдсан ажил	
		Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг
1	Цахилгаан эрчим хүч нэмэгдүүлэх ажил	28	2064.9	18	2029.4
2	Авто засвар шинэчлэлийн ажил	18	6754.4	8	1247.2
3	Инженерийн шугам сүлжээний шинэчлэлт, засварын ажил	27	5360.6	43	5856.2
4	Байгаль орчин, ногоон байгууламж, тохижилтын чиглэлээр хийх ажил	7	123.3	26	679.5
5	Барилга засварын ажил	34	4889.6	89	10169.2
6	Бараа худалдан авах	65	2095.8	43	2551.8
7	Авто машин худалдан авах	2	245.7		
8	Бусад, зөвлөх үйлчилгээ	20	2093.8	36	1587.5
9	Авто замын сангаар			8	637.1
10	Эрдэнэт сангаар			4	56.6
Нийт ажлын дүн		201	23628.1	275	24814.5

Тайлант онд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудын 8.1%-ийг цахилгаан эрчим хүч, 5%-ийг авто зам, засвар шинэчлэлтийн ажил, 23.5%-ийг инженерийн шугам сүлжээний шинэчлэлт, засварын ажил, 41%-ийг барилгын их засварын ажил, 10.3%-ийг бараа, тоног төхөөрөмж, авто машин худалдан авах, 6.4%-ийг бусад зөвлөх үйлчилгээнд зарцуулахаар баталсан байна.

Дээрх хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөртэй уялдсан эсэхийг аудитад хамрагдсан ажлуудтай түүвэрчлэн шалгахад:

Орхон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөөг дараах 9 чиглэлээр хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-ын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан байна. Үүнд:

- Эрүүл-аз жаргалтай иргэд
- Нийгмийн дэмжлэгтэй- аз жаргалтай иргэд
- Ажилтай- аз жаргалтай иргэд
- Оюунлаг, ёс зүй, соёлтой-аз жаргалтай иргэд
- Эрүүл хүнс, цэвэр орчинтой-аз жаргалтай иргэд

- Сайхан хотын-аз жаргалтай иргэд
- Аялал жуулчлалын өгөөжтэй-аз жаргалтай иргэд
- Эдийн засгийн өсөлттэй-аз жаргалтай иргэд
- Чадварлаг засаглалтай-аз жаргалтай иргэд гэсэн 9 чиглэл

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд

- 1-2 сургуулийн гаднах биеийн тамирын талбайг иж бүрэн тохижуулах гэж заасны дагуу Эрдэм ахлах сургуулийн гадна биеийн тамирын талбай тохижуулах ажилд 51.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн байна.
- Багуудад хүүхэд залуучууд болон оршин суугчдын амралт чөлөөт цагийг өнгөрүүлэхэд зориулсан “ Чөлөөт цагийн талбай” дэд хөтөлбөр боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлэх гэж заасны дагуу 12 байршилд хүүхдийн тоглоомын талбай болон амралт чөлөөт цагийн талбайд 738.5 сая төгрөг зарцуулсан байна.
- ӨЭМТ-ийг цогц байдлаар зохион байгуулах гэж заасны дагуу 3 хороололд өмнөх онд баригдсан ӨЭМТ-ийн дутуу санхүүжилт 349.3 сая төгрөг, энэ онд шинээр баригдсан ӨЭМТ-д 1120.0 сая д төгрөгийг тус тус зарцуулсан байна.
- Эмчилгээ оношлогоо, лабораторийн тоног төхөөрөмжийг сайжруулж материаллаг баазыг нэмэгдүүлэх гэж заасны дагуу БОЭТ-ийн материаллаг баазыг нэмэгдүүлж 316.4 сая төгрөгөөр тоног төхөөрөмж, эмнэлэгийн засвар үйлчилгээнд 189.0 сая төгрөг тус тус зарцуулсан байна.
- Даваат багт 100 хүүхдийн цэцэрлэг 180 хүүхдийн бага сургууль бүхий цогцолборын барилгыг барьж дуусгах, биеийн тамирын талбайг тохижуулах гэж тусгагдсаны дагуу 280 хүүхдийн сургууль цэцэрлэгийн ажлыг 1348.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэн ашиглалтанд хүлээлгэн өгсөн байна.
- Сургууль цэцэрлэгийн барилгад их засвар үйлчилгээ хийх гэж заасны дагуу тухайн онд 8 сургууль цэцэрлэгт 407.8 сая төгрөгийн барилгын засвар, 5 сургууль цэцэрлэгт 102.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж тус тус баталж зарцуулсан байна.

Энэ нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүд нь аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөр, 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдсан гэж дүгнэхээр байна.

1.2 Хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлоогүй, үр ашиггүй хөрөнгө оруулалтын ТАХ төлөвлөж хөрөнгө зарцуулсаар байна.

Хөрөнгө оруулалтын ТАХ-ээс 11 ТАХ-ний 1388.5 сая төгрөг буюу нийт хөрөнгө оруулалтын 6% нь төлөвлөлт оновчгүй байгаагаас хамааран үр дүнгүй хөрөнгө оруулалт болсон байна.

Үр дүн үр ашиггүй хөрөнгө болсоны гол шалтгаан нь :

- Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг ашиглахтай холбогдсон зардлыг төсөвт суулгаагүй.
- Ажлын гүйцэтгэл хангалтгүй чанаргүй хийгдсэн.
- Ашиглах боломжгүй байхад урьдчилан хөрөнгө зарцуулсан.
- Иж бүрэн ашиглалтанд хүлээлгэн өгөөгүйн улмаас ашиглалтгүй болсон.
- Иргэдийн амжиргааны түвшинг бодитой үнэлээгүйгээс иргэдэд олгосон гэрийг ашиглаагүй, тухайн иргэн зарж үрэгдүүлсэн.
- Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг ашиглаагүй, ашиглалтанд хяналт хэрэгжүүлээгүй.

- Үзүүлэлт сайтай компьютер худалдан авах боломжтой хөрөнгөөр техникийн тодорхойлолт бодитой, үндэслэлтэй хийгдээгүйгээс үзүүлэлт бага нөтбүүк худалдан авсан нь ашиглалт хангалтгүй зэрэг шалтгааны улмаас хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил үр дүнгүй болсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29.2 “Хөрөнгө оруулалтын төслийн санал дүнд үндэслэсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна” гэсэн зүйл заалтыг зөрчсөн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд орон сууцны хорооллын нийт 237 орцны хаалгыг 496.4 сая төгрөгөөр соронзон кодтой хаалгаар солих ажил хийгдсэн байна.

Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 15.1.1-т зааснаар орон сууцны хаалга нь орон сууцны байшингийн дундын өмчлөлд хамаарна гэж заасан байна.

Хөрөнгө оруулалтаар хийгдсэн соронзон кодтой хаалганууд нь эзэнгүйдэж, үр дүнгүй хөрөнгө оруулалт болох үр дагавартай байна.

Аудитын явцад СӨХ-дын орлогын хэмжээг судалж үзэхэд 2.5-111.7 сая төгрөгийн орлоготой ажилдаг байна.

Орхон аймагт нийт 31 СӨХ ажилладаг бөгөөд нийт 660 орцны хаалгатай, үүнээс 2013-2016 онд нийт 380 хаалгыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр, 64 хаалгыг СӨХ өөрийн хөрөнгөөр хийж, нийт 444 хаалга соронзон кодтой болсон байгаа нь нийт хаалганы 67.3 хувийг эзэлж байна.

Нэг соронзон кодтой хаалгыг 1.9 сая төгрөгөөр орон нутгийн төсвөөр хийсэн нь СӨХ-дийн өөрсдийн хийж байгаа өртгөөс нэг дахин өндөр өртгөөр хийгдсэн байна.

Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 12.4.3-т “холбооны мөнгөн хөрөнгийг түүний зорилго, үйл ажиллагааны чиглэл, бүх гишүүдийн хурлын шийдвэрт нийцүүлэн энэ хууль, хууль тогтоомжийн бусад акт болон холбооны дүрмээр олгосон эрх хэмжээний дотор зөвхөн дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээ, бусад нийтлэг зардалд зориулан захиран зарцуулах” гэсэн үндсэн чиг үүрэгтэй, санхүүгийн орлогын хэмжээнээс харахад СӨХ-д өөрсдөө орцны хаалгаа солих бүрэн боломжтой байхаар байна.

Дээрх 496.4 сая төгрөгөөр орон сууцны орцнуудын хаалгыг соронзон кодтой хаалгаар солих ажилд орон нутгаас хөрөнгө төлөвлөж, баталж, зарцуулах шаардлагагүй байсан гэж дүгнэлээ.

Түүнчлэн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлаас нэг байршилд буюу 4 дүгээр хороололд Өрхийн эрүүл мэндийн цогц төв барих ажил болон Хүрэнбулаг багийн 4-22, 4-25-р байр орчмын явган замын ажлууд нэг ижил цаг хугацаанд хийгдэхээр төлөвлөгдсөн байна.

Явган хүний замын ажлыг гэрээт хугацаа болох 2016 оны 06 дугаар сарын 18-нд хүлээлгэн өгч санхүүжилтээ бүрэн авсан боловч ӨЭМТ-ийн барилгын ажил дуусаагүй, тус хийгдсэн явган хүний замаар том даацын машинаар цутгалт хийх, барилгын материал буулгах зэргээс шалтгаалан хийгдсэн явган хүний замын зарим хэсэг эвдэрсэн байна.

Анх хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөхдөө томоохон барилгын ажлаа дууссаны дараа явган хүний замд хөрөнгө зарцуулсан бол үр ашиггүй, чанаргүй ажил хийгдэхгүй байсан байна.

Иймд хөрөнгө оруулалтын үр ашиг, ашиглалтыг сайжруулахын тулд урьдчилан судалж, оновчтой төлөвлөх шаардлагатай байна.

Мөн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 23441.3 сая төгрөгийн ТАХ-ний жагсаалтад хөрөнгө оруулалтын шинж чанаргүй, урсгал зардлын шинжтэй 50 ТАХ-нд 2489.3 сая төгрөгийн төсөл хөтөлбөрийг баталсан байна.

Эдгээр төсөл хөтөлбөрүүд нь орон нутгийн хөрөнгө оруулалтын данснаас зарцуулагдахгүй хэдий ч ИТХ-ын тогтоолын төсвийн жилд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын ажлын дээд хэмжээг баталсан дүнд орсон байна.

Иймд хөрөнгө оруулалтаар хийгдэх ТАХ-ний жагсаалтыг батлахдаа хөрөнгө оруулалтын шинж чанартай, шинж чанаргүй төсөл арга хэмжээг ялгаж, хөрөнгө оруулалтын шинж чанаргүй урсгал зардлын шинж чанартай төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын дүнд оруулан батлахгүй байх шаардлагатай байна.

1.3 Техникийн нөхцөлийн иж бүрэн байдал хангалтгүй байхад зураг төсөл хийгдсэн байна.

Орхон аймагт 2016 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаар дараах томоохон хэмжээний бүтээн байгуулалтын ажил хийгдсэн байна. Үүнд:

- Өрхийн эрүүл мэндийн төвийн цогц барилга барих /1,4,5 хороолол/ 1120.0 сая төгрөг
- Даваат багт 280 хүүхдийн цэцэрлэг, сургуулийн цогцолборын барилгыг барьж эхлүүлэх 2329.8 сая төгрөг
- Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн цогц барилга /он дамжсан нийт 1521.1 сая төгрөг/
- "Эрдэнэт амьдрал" ХХК-ийн оффисын дуусаагүй барилгыг төрийн байгууллагын оффисын зориулалтаар өөрчилж барьж дуусгах 918.5 сая төгрөг

Дээрх бүтээн байгуулалтын ажилд газрын зөвшөөрөл олгогдож аймгийн Засаг даргын захирамжууд гарсан байна.

Барилгын тухай хуулийн 4.1.8-д “барилга байгууламжийн техникийн нөхцөл” гэж барилга байгууламжийг дулаан, уур, хий, цэвэр, бохир ус, цахилгаан, харилцаа холбоо, дохиолол зэрэг эх үүсвэрт холбох эрх бүхий хуулийн этгээдээс гаргах шийдвэрийг” гэж заасны дагуу дээрх 4 барилгын ажил нь усан хангамж, ариутгах татуургын төвлөрсөн системд хэрэглэгчийг холбох техникийн нөхцөлийг “Эрдэнэт Ус ДТС” ХК-аас, дулаан халаалтын техникийн нөхцөлийг ЭДЦС ХК-ас, цахилгаан эрчим хүчний техникийн нөхцөлийг ЭБЦТС ТӨХК-аас, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Орхон аймаг дах газраас холбоожуулалтын техникийн нөхцөлийг тус тус авсан байна.

Харин Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн цогц барилга, Даваат багийн 280 хүүхдийн цэцэрлэг, сургуулийн барилга, "Эрдэнэт амьдрал" ХХК-ийн оффисын дуусаагүй барилгыг төрийн байгууллагын оффисын зориулалтаар өөрчилж барьж дуусгах ажлууд нь холбоожуулалтын техникийн нөхцөлийг аваагүйн улмаас уг барилгууд шуудан холбоо болон интернет холболтод холбогдоогүй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 4.1.8-д “барилга байгууламжийн техникийн нөхцөл” гэж барилга байгууламжийг дулаан, уур, хий, цэвэр, бохир ус, цахилгаан, харилцаа холбоо, дохиолол зэрэг эх үүсвэрт холбох эрх бүхий хуулийн этгээдээс гаргах шийдвэрийг”, 12.1.1-т “эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл, зургийн даалгавар, норм, нормативын баримт бичиг, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, техникийн нөхцөл, инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулагдсан байх” гэсэн зүйл заалтыг зөрчсөн байна.

Мөн Өрхийн эрүүл мэндийн төвийн цогц барилга барих /1,4,5 хороолол/ ТАХ нь техникийн нөхцөл бүрэн авсан боловч ажлыг гүйцэтгэсэн “Сэхүүн чоно” ХХК нь чанаргүй эсвэл холболт буруугаас шалтгаалан барилгын өрөөнүүдэд холбоо болон интернет ажиллахгүй байна.

Иймд гүйцэтгэгч байгууллагад чанаргүй гүйцэтгэсэн ажлыг дахин гүйцэтгүүлж ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх тухай хугацаатай албан шаардлага хүргүүлэв.

2007 онд “Эрдэнэт амьдрал” ХХК-ийн насосны станц, усны тоолуурын лабораторийн зориулалтаар баригдаж байсан барилгыг өөрчлөн “Эрдэнэт амьдрал” ХХК-ийн оффисын дуусаагүй барилгыг төрийн байгууллагын оффисын зориулалтаар өөрчилж барьж дуусгах ажил болгосон бөгөөд дулааны техникийн нөхцөлийг 2007,2008 онд, цахилгааны техникийн нөхцөлийг 2010 онд тус тус гаргасан байна.

Дутуу баригдсан барилгыг дахин өөрчлөн барихдаа өмнө нь хийгдсэн техникийн нөхцөл нь Эрчим хүчний сайдын тушаалаар 2012 онд батлагдсан Цахилгаан эрчим хүчээр хангах техникийн нөхцөл олгох журмын 3.9-д “Техникийн нөхцөлийн хүчин төгөлдөр байх хугацааг объектод гүйцэтгэх ажлын хэмжээнээс хамааран 1-3 жилээр тогтооно” гэж заасны дагуу хүчингүй болсон байна.

Холбогдох газруудаас техникийн нөхцөл дахин гаргуулаагүй, холбоожуулалтын техникийн нөхцөлийг огт аваагүй байхад 2015 онд аймгийн ЗДТГ-ын хуулийн хэлтсийн даргын захиалгаар зориулалт өөрчилсөн ажлын зургийг ШУТИС, зураг төсөл судалгааны төвөөр хийлгэсэн байна.

Гэтэл зураг төсөл хийгдэж, ажлаа гүйцэтгэсэний дараа цахилгаан эрчим хүчээр хангах 16/037 дугаарын техникийн нөхцөлийг 2016 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр “Эрдэнэт Ус, ДТС” ОНӨХК-аар гаргуулсан байна.

Энэ нь захиалагч анх хөрөнгө оруулалтын ТАХ-ний зураг төслийг гаргуулахдаа техникийн нөхцөлийн иж бүрэн байдлыг харгалзан үзээгүйгээс одоогийн хийгдсэн ажилд гаднах цахилгааны шугам сүлжээний болон холбоожуулалтын ажил огт хийгдээгүй үлдсэнээс цаг хугацаа болон хөрөнгийн эх үүсвэр дахин шаардлагатай болохоор байна.

Иймд цаашид захиалагчийг төлөөлөн зураг төсөл гүйцэтгүүлэхээр санал хүргүүлэхдээ техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа, иж бүрэн байдлыг зайлшгүй харгалзан үзэж зураг төслийг боловсруулж байх шаардлагатай байна.

Мөн шинээр баригдахаар төлөвлөж буй барилгын газрын зөвшөөрлийг олгохдоо байшингийн суурийн хэмжээгээр газрын талбайн хэмжээг олгож байгаагаас шалтгаалан тухайн барилгад гадна тохижилт болон хамгаалалтын хашаа зэргийг хийх боломжгүй болсон байна.

Иймд барилга байшин барихаар төлөвлөж буй байршилд газрын зөвшөөрлийг олгохдоо барилгын норм ба дүрэм, стандартыг үндэслэн гадна тохижилт, хашаа, хамгаалалтын бүсийг төлөвлөх боломжтой байхаар газрын хэмжээг шийдвэрлэж байх шаардлагатай байна.

1.4 ТАХ-ний ТЭЗҮ, зураг төсөл иж бүрэн, дэвшилтэт технологиор хийгдсэн эсэхийг хянаж, ИТХ-аар батлахдаа бөөн дүнгээр батлахгүй байх шаардлагатай байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар авто зам засвар өргөтгөлийн 22 ТАХ-нд 2861.4 сая төгрөг, инженерийн шугам сүлжээний 27 ТАХ-нд 3398.7 сая төгрөг, гэрэлтүүлэгийн 23 ТАХ-нд 1385.3 сая төгрөг, барилгын их засварын 55 ТАХ-нд 4399.5 сая төгрөг, шинэ барилга байгууламжийн 4 ТАХ-нд 4367.7 сая төгрөг, ногоон байгууламжийн 2 ТАХ-нд 77.8 сая төгрөг нийт 133 ТАХ-нд 16490.4 сая төгрөг баталсан байна.

Үүнээс авто зам засварын 22 ТАХ зураг төсөлтэй, ИШС-ний 25 ТАХ зураг төсөлтэй, 2 ТАХ зураг төсөлгүй, ногоон байгууламжийн 2 ТАХ зураг төсөлтэй, гэрэлтүүлэгийн 21 ТАХ зураг төсөлтэй, 2 ТАХ зураг төсөлгүй, барилгын засварын 53 ТАХ зураг төсөлтэй, 2 ТАХ зураг төсөлгүй, нийт 6 ТАХ зураг төсөлгүй байна. Үүнд:

- 11-р хороололд байршилтай 2*2000м³ резервуарыг түвшний мэдрэгч автомат удирдлагатай болгох, 22,4 сая төгрөг
- Бүрэнбүстийн эх үүсвэрийн цэвэр усны шугамыг /УДШ-1/ хос шугам болгох, 174,0 сая төгрөг
- Даваат багт 160 ква дэд өртөө, 6/0.4 кв ЦДАШ барих, 60,1 сая төгрөг
- Гэр хорооллын Нэг цонхны үйлчилгээний төвд эд хөрөнгийн бүртгэл хийх нөхцөл бүрдүүлэх /шилэн кабель татах /, 34,4 сая төгрөг
- Их шүтээн цогцолборын гол барилгын нүүр талыг металл хавтангаар өнгөлөх ажил, 10.0 сая төгрөг
- Онцгой байдлын харьяа Эрдэнэ багт байрлах гал унтраах ангийн тусгай зориулалтын автомашины гражийн барилга, 58.5 сая төгрөг

Дээрх 6 ТАХ-ээс Гэр хорооллын Нэг цонхны үйлчилгээний төвд эд хөрөнгийн бүртгэл хийх нөхцөл бүрдүүлэх /шилэн кабель татах / 34.4 сая төгрөгийн ажил нь Мэдээлэл холбооны сүлжээний Орхон аймаг дахь салбараас холбоожуулалтын техникийн нөхцөл гаргуулан, ХББЗА ОНӨҮГ төсөв хийсэн байна.

Хотын ИШС-ний засвар шинэчлэлтийн ажилд 300.0 сая төгрөг бөөн дүнгээр батлагдсан. Үүнээс зураг төсөлгүй ажил нь 65.5% буюу 196.4 сая төгрөгийн 2 ТАХ байна. Мөн цахилгаан хангамжийг сайжруулах 220.0 сая төгрөг бөөн дүнгээр батлагдсанаас зураг төсөлгүй ажил нь 43% буюу 94.5 сая төгрөгийн 2 ТАХ байна.

Бөөн дүнгээр батлагдсан ажлууд нь зураг төсөлгүй, иж бүрэн бус байх эрсдэлтэй байхаар байна.

Эдгээр нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 48.3.”Төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор энэ хуулийн 45.4-т заасан худалдан авах бараа, ажил, үйлчилгээний захиалгыг төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийн хамт худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд цаашид хөрөнгө оруулалтын ажлыг бөөн дүнгээр батлахгүй, ТАХ-ний нэр тус бүрээр задалж байх шаардлагатай байна.

Зураг төсөл: 2015 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаар 4 байршилд УДДТ барьж гүйцэтгэн 1641.9 сая төгрөг зарцуулсанаас 3 УДДТ нь хамгаалалтын хашаатай байсан бол Баянбулаг багт хийгдсэн УДДТ нь хамгаалалтын хашаа болон цонхны решотка хийгдээгүй байсан.

2016 оны хөрөнгө оруулалтаар Баянцагаан баг болон орон сууцны 2-р хороололд УДДТ барих ажилд нийт 1007.3 сая төгрөг зарцуулсан боловч хамгаалалтын хашаа зурвас хийгдээгүй нь зураг төсөлд анхнаасаа хамгаалалтын бүсийг тусгаагүйтэй холбоотой байна.

Энэ нь Усны тухай хуулийн 22.1-т ” Усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс тогтооно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Түүнчлэн Их залуу багийн ИШС-ний өргөтгөлийн ажлыг ХЗА-ны захиалгаар Эрдсанбар ХХК-ийн хийж гүйцэтгэсэн зургийн дагуу 75.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэн ашиглалтанд оруулахдаа ХЗА-ны хүсэлтээр зурагт өөрчлөлт оруулан уурын зуухны нүүрс хадгалах, үнс гаргах савыг магадлашгүй ажлын зардлын 1.4 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн байна.

Нүүрс хадгалах, үнс гаргах савны зураг төсөл нь барилгын онцлогт тохирсон дэвшилтэт санааг тусгаагүй, дээвэр битүү хийгдсэнээс нүүрс, үнсийг хийж зөөвөрлөхөд тохиромжгүй байхаар хийгдсэн байна.

Нүүрс, үнсний сав нь айл өрхийн хэмжээнд хэрэглэгдэх жижиг амбаар мэт хийгдсэн байх ба гурван тогоогоор ажилдаг уурын зуухны нүүрс, үнсийг гар аргаар зөөж оруулах, буцааж зөөж түлэх зорилгоор баригдсан байна.

Хэдийгээр нүүрс, үнс газарт тараахгүй орчныг бохирдуулахгүй гэсэн зорилго нь зөв хэдий ч түлх нүүрсний хэмжээг тооцож машинаас шууд нүүрс хийх, цугларсан үнсийг машинд ачих боломжтой хэлбэрээр хийсэн бол ашиглах боломж бүрдэхээр байна.

Одоогийн байдлаар нүүрс, үнс хийх зорилулалтаар баригдсан 2 амбаар нь ашиглалтгүй, үр ашиггүй хөрөнгө оруулалт болсон байна.

Амралт чөлөөлт цагийн талбай байгуулах ажилд /Шанд багт/ 50.0 сая төгрөг баталж, 49.9 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр Шилтгээн таун ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.

Уг тоглоомын талбайн анхны зураг төсөл нь Шанд багийн 22,35 дугаар гудамжинд хийгдэхээр төлөвлөгдсөн байтал тоглоомын талбайн ард АТП-280, 0.4 кв-ын агаарын шугам таарсан тул ажлын зургийг өөрчилж талбайн хэмжээг багасгасан байна.

Шанд багийн 22,35 дугаар гудамжид хийгдсэн тоглоомын талбайн доогуур МОН 2301 цэвэр усны шугам явсан, талбайгаас 10 м хүрэхгүй газарт цахилгааны 380 вольтын эх үүсвэр холбоотой, АТП-280, 0.4 кв-ын агаарын шугам таарсан байна.

Энэ нь ХББЗА ОНӨҮГ тус талбайд амралт чөлөөт цагийн талбай байгуулах тохиромжтой эсэхийг судлаагүй, судалгаа тооцоолол муутай зураг төсөл хийсэнтэй холбоотой байна.

Иймд зураг төсөл хийхдээ барилгын онцлог болон дэвшилтэт технологийг тусгаж, үр ашигтай, ашиглах боломж бүрдэж байгаа эсэхийг тооцон, зурагт бүрэн тусгасан эсэхэд хяналт хэрэгжүүлж байх шаардлагатай байна.

Түүнчлэн барилгын ажлын зураг төслийг боловсруулахад тодорхой хугацаатай байдаг боловч богино хугацаанд шахсанаас зураг төсөл оновчгүй, дутуу хийгдэх эрсдэл үүсдэг байна.

ТЭЗҮ: Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудаас дараах ТАХ-нд техник эдийн засгийн үндэслэл зайлшгүй байх шаардлагатай байтал ТЭЗҮ огт хийгдээгүй байна. Үүнд:

- Өрхийн эрүүл мэндийн төвийн цогц барилга барих /1,4,5 хороолол/ 1120.0 сая төгрөг
- Даваат багт 280 хүүхдийн цэцэрлэг, сургуулийн цогцолборын барилгыг барьж эхлүүлэх 2329.8 сая төгрөг
- Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн цогц барилга /он дамжсан нийт 1521.1 сая төгрөг/
- "Эрдэнэт амьдрал" ХХК-ийн оффисын дуусаагүй барилгыг төрийн байгууллагын оффисын зориулалтаар өөрчилж барьж дуусгах 918.5 сая төгрөг

Энэ нь Засгийн газрын 2009 оны 204 дүгээр тушаалаар баталсан барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрмийн 3.7-д “Онцгой зохицуулалттай объект болон тусгай зориулалтын барилга байгууламж, томоохон цогцолбороор барих үйлдвэр-аж ахуйн газар, орон сууцны хороолол, стратегийн ач холбогдолтой шугаман байгууламжийн зураг төсөлд техник-эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг боловсруулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд цаашид тус журамд нийцүүлэн томоохон цогцолбор бүтээн байгуулалтын ажилд техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж үр ашгийг тооцсоны дараа ИТХ-д өргөн

мэдүүлэх, ТАХ-г батлуулах шаардлагатай байх тул аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэс, Хотын захирагчийн албанд зөвлөмжөөр хүргүүлэв.

1.5 Болзошгүй аваарын зардлаас хөрөнгө зарцуулахдаа ОБГ, МХГ-ын дүгнэлт гараагүй ТАХ-нд хөрөнгө зарцуулсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ТАХ-ний ажлын жагсаалтыг аймгийн ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 5 дугаар тогтоолоор баталсан ба 3 удаа төсөвт тодотгол хийсэн.

Төсвийн тодотголоор дараах ТАХ-ний анхны батлагдсан төсөвт өөрчлөлт орсон байна.

Үүнд: /сая.төгрөг/

№	Төсөл арга хэмжээний жагсаалт	2015-12-3 №5 тогтоол	2016-08-17 №11 тогтоол	Нэмэгдсэн дүн
1	Болзошгүй аваарын зардал	500.0	1269.3	769.3
2	Жаргалант суманд 500тн ногооны зoorь үргэлжлүүлэн барих	146.0	164.0	18.0
3	"Эрдэнэт амьдрал" ХХК-ийн оффисын дуусаагүй барилгыг төрийн байгууллагын оффисын зориулалтаар өөрчилж барьж дуусгах	660.4	943.0	282.6
4	Өрхийн эрүүл мэндийн цогц төв барьж эхлүүлэх /1.4.5-р хороолол/	700.0	1120.0	420.0
5	Баянцагаан багт автомашины гарц барих /мал түүхий эдийн нэгдсэн зах/	110.0	187.4	77.4
	Нийт дүн	2116.4	3683.7	1567.3

Анхны батлагдсан төсөвт өөрчлөлт орсон дээрх 5 ТАХ нь 2015 оны ИТХ-ын 5 дугаар хуралдаанаар 2116.4 сая төгрөгөөр баталсан боло төсвийн тодотголоор 3683.7 сая төгрөг болгож 1567.3 сая төгрөгийг нэмж баталсан байна.

Томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг тухайн оны хөрөнгө оруулалтын төсвөөс шалтгаалан барьж эхлүүлэх төсвийг анх батлуулж, төсвийн тодотголоор үлдэгдэл санхүүжилтийг нэмж баталсан байна.

Харин Болзошгүй аваарын зардалд 1269.3 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 87 ажилд 1249.8 сая төгрөг зарцуулсан байна.

Аймгийн Засаг даргын 2016 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн А/504 дүгээр захирамжийн 3 дугаар хавсралтаар Болзошгүй аваарын зардлаас хөрөнгө гаргах журмыг баталсан байна.

Болзошгүй аваарын зардлыг захиран зарцуулах журмын 3.4-т “ Болзошгүй аваарийн зардлаас зардал гаргах зайлшгүй шаардлага гарсан нөхцөлд хариуцагч хуулийн этгээд ажилтан шаардлагатай бол тухайн тойргийн төлөөлөгч нь уг арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө, ОБГ-ын байцаагчийн дүгнэлт, Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт, төсвийн зардлын зүйлээр хийсэн дэлгэрэнгүй тооцооны хамт ХЗА-нд ирүүлнэ” гэсэн заалт тусгагдсан .

Гэтэл болзошгүй аваарын зардлаас явган хүний зам, гарц хийх 4 ажилд 51.0 сая төгрөг, ЦДАШ-ийн 2 ажлын дутуу санхүүжилт 66.7 сая төгрөг, Ёслол хүндэтгэлийн өргөөний гадна тохижилтын засварын ажилд 3.8 сая төгрөг, ОБГ-т тэмцээн зохион байгуулах зардалд 3.8 сая

төгрөг, багуудад хайрган болон хатуу хучилттай авто замын 6 ажилд 78.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын А/192, А/480 тоот захирамжаар захиран зарцуулсан байна.

Эдгээрийн зарцуулалтын баримтнаас харахад ОБГ, МХГ-ын дүгнэлт гараагүй ТАХ-нд санхүүжилт олгосон байна.

Иймд болзошгүй аваарын зардлаас санхүүжүүлэх ТАХ-ний ОБГ, МХГ-ын байцаагчийн дүгнэлтийг үндэслэж байх, санхүүжилт олгохдоо баримтын бүрдлийг бүрэн бүрдүүлсэний дараа олгож байх талаар СТСХ-т зөвлөмжөөр хүргүүлэв.

1.6 Хөрөнгө оруулалтаар хийгдэх ТАХ-ний онцлог байдлыг харгалзан үзэж гүйцэтгэх хугацааг улиралын байдалтай зохицуулж байх шаардлагатай байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалалтаар орон сууцны байрны фасадны засварын ажилд 1347.9 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 1339.4 сая төгрөг зарцуулсан байна.

Орон сууцны байрны фасадны засварын ажлаас орон сууцны 1,4,5-р хорооллын байрны гадна фасадны засвар “Эрдэнэт үйлдвэр” ХХК, аймгийн ЗДТГ-ын хамтын ажиллагааны хүрээнд хийгдэж 907.8 сая төгрөгийг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн дансанд шилжүүлсэн байна.

Фасадны ажил хийсэн хугацаанаас үзэхэд 6 байрны фасадны ажил гүйцэтгэх хугацаа нь 2 дугаар сарын 29-ны өдрөөс 5 дугаар сарын 20 хүртэл, 4 байрны фасадны ажил нь 9 дүгээр сарын 26-ны өдрөөс 10 дугаар сарын 25-ны өдрийн хугацаатай байгаа нь тохиромжгүй байна.

Учир нь тухай саруудад цаг агаарын байдал хүйтэн, хийгдсэн эмульс болон шавардлагын ажил хатахгүй хөлдөж улмаар гүйцэтгэсэн ажил чанарын доголдол үүсэх эрсдэлтэй улиралд ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан байна.

Мөн Говил багийн 37 айлын сууц, “ЭҮ”-н цагдаа орчмын үерийн хамгаалтын суваг хийх ажлыг 63.3 сая төгрөгөөр Жавхлан харгуй ХХК гүйцэтгэхдээ 2016 оны 9 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 1-ны өдөр хүртэл гүйцэтгэсэн нь хүйтний улиралд хийгдсэн зуурмаг хаталгүй хөлдөж одоогийн байдлаар үйрч унасан байдалтай болсон, шүүлтүүр металл рещётка авто машины даац даахгүй эвдэрсэн байхад санхүүжилтаа бүрэн авсан байна.

Иймд цаашид тухайн ажлын онцлог байдлыг харгалзан үзэж, тохиромжтой улиралд ажлыг гүйцэтгүүлэх гэрээ байгуулж байх шаардлагатай байна.

1.7 Шилжих үлдэгдлээс 4005.8 сая төгрөгийн 71 ТАХ хэрэгжихээр батлагдсан байна.

2015 онд дутуу санхүүжсэн 2016 он дамжин санхүүжих ТАХ-ны жагсаалтад Байгаль хамгаалах сангийн 4 ТАХ 411.6 сая төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтын 5 ТАХ 1152.4 сая төгрөг, шилжих үлдэгдлээр 110 ТАХ-ний 4163.0 сая төгрөг, болзошгүй аваарын зардлаар 5 ТАХ 121.6 сая төгрөг нийт 124 ТАХ-ний 5848.6 сая төгрөгийн ажил батлагдсан байна.

2015 онд төвлөрүүлсэн дүн, 2016 он дамжин санхүүжихээр батлагдсан дүн 949.9 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь хөрөнгө оруулалтын ажлын хэмнэлт болон магадлашгүй ажлын санхүүжилт байна.

Харин он дамжин шилжиж санхүүжүүлэхээр батлагдсан 5848.6 сая төгрөгөөс 4.4 сая төгрөгийн хэмнэлт гаргаж, 5844.2 сая төгрөгийг зарцуулахаас 4911.5 сая төгрөг зарцуулж, 932.7 сая төгрөг зарцуулаагүй үлдсэн байна.

Зарцуулаагүй үлдсэн 277.6 сая төгрөг нь гүйцэтгэгчид олгох баталгааны 5%, 363.4 сая төгрөг нь гүйцэтгэгчид олгох дутуу санхүүжилт, 291.7 сая төгрөг нь техник хяналтын зардал болон зураг төсвийн зардлын үлдэгдлүүд байна.

Харин 2016 онд 21481.9 сая төгрөгийн ТАХ батлагдсанаас огт хэрэгжээгүй 9 ТАХ –ний 572.1 сая төгрөг, гүйцэтгэгчид 17790.5 сая төгрөг олгож 3119.3 сая төгрөг үлдсэн байна.

Энэ нь гүйцэтгэлийн баталгааны 5%-ийн 546.7 сая төгрөг, гүйцэтгэгчид олгоогүй дутуу санхүүжилт 1595.7 сая төгрөг, техник хяналт зураг төсвийн зардал 377.8 сая төгрөг, хөрөнгө оруулалтын ажлын хэмнэлт 599.0 сая төгрөг байна.

Эндээс үзэхэд 2015 оны үлдэгдэл 932.7 сая төгрөг, 2016 оны үлдэгдэл санхүүжилт 2520.2 сая төгрөг, нийт 3452.9 сая төгрөгийн ТАХ 2017 онд он дамжин хэрэгжихээр байна.

Харин 2017 оны батлагдсан төсвөөс үзэхэд өмнөх оны үлдэгдэл санхүүжилт 71 ТАХ-ний 4005.8 сая төгрөг батлагдаж 552.9 сая төгрөгөөр зөрүүтэй батлагдсан нь түрээсийн орон сууц хэрэгжүүлэх дүн орсонтой холбоотой байна.

Бүлэг 2: Гүйцэтгэгчид нэг ижил цаг хугацаанд 2 ба түүнээс дээш ажил гүйцэтгэсэнээс зарим ажил чанаргүй болсон, тендерт оролцогчийн талаарх мэдээллийн сан хангалтгүй байна.

2.1 Үнэлгээний хороог журмын дагуу зохион байгуулж, худалдан авах ажиллагааны ил тод, байдлыг хангасан байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд орон нутгийн хөрөнгө оруулалтын авто зам засвар шинэчлэлийн 18 ТАХ-нд 2861.4 сая төгрөг, инженерийн шугам сүлжээний шинэчлэлт, засварын 27 ТАХ-нд 3398.7 сая төгрөг, гэрэлтүүлэг цахилгааны 23 ТАХ-нд 1385.3 сая төгрөг, барилгын засварын 59 ТАХ-нд 4464.8 сая төгрөг, шинээр хийх барилга угсралтын ажил 4 ТАХ-нд 4367.7 сая төгрөг, ногоон байгууламжийн 3 ТАХ-нд 127.8 сая төгрөг, тавилга эд хогшил тоног төхөөрөмж худалдан авах 58 ТАХ-нд 3589.8 сая төгрөг нийт 192 ТАХ-нд 20195.8 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар тусгагдсан байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан 192 ТАХ-ний худалдан авах ажиллагаанд мөрдсөн журмыг хүснэгтээр харуулбал: /сая.төгрөг/

№	Ажлын төрөл	Худалдан авах ажиллагааны журам					
		НТШ	Шалгарсан дүн	ХА	Шалгарсан дүн	ШХА	Шалгарсан дүн
1	Авто зам засвар шинэчлэл	8	2255.1	10	578.5	0	0
2	Инженерийн шугам сүлжээ	8	2395.3	17	873.2	2	87.3
3	Гэрэлтүүлэг	3	473.2	20	891.0		
4	Барилгын их засвар	5	2062.1	51	2321.3	3	28.2
5	Шинэ барилга байгууламж	4	4114.8				
6	Ногоон байгууламж			3	127.6		
7	Тавилга эд хогшил	14	2411.4	31	1037.3	13	116.2
	Нийт	42	13711.9	132	5828.9	18	231.7

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47.1-д “Бараа ажил, үйлчилгээний төсөвт өртөг энэ хуулийн 8.1.1-д заасан дээд хязгаараас давсан тохиолдолд захиалагч үнэлгээний хороо байгуулна” гэж заасны дагуу босго үнэ давсан 42 төрлийн ТАХ-нд НТШ-ын аргаар сонгон шалгаруулах үнэлгээний хороог аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар байгуулсан байна.

Мөн хуулиар харьцуулалтын аргаар зохион байгуулж буй худалдан авах ажиллагаанд зайлшгүй үнэлгээний хороо байгуулна гэсэн хуулийн заалт байхгүй хэдий ч аймгийн худалдан авах ажиллагааны алба харьцуулалтын аргаар зохион байгуулсан 132 ТАХ-ний 66 ТАХ буюу 50%-д нь үнэлгээний хороо байгуулж ажилласанаар ашиг сонирхолын зөрчил үүсэхээс сэргийлж, дотоод хяналт хэрэгжүүлж ажилласан нь сайшаалтай байна.

Өмнөх онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааг энэ оны худалдан авах ажиллагаатай харьцуулбал:

№	Тендер шалгаруулалтын төрөл	2015 он	2016 он	Өсөлт бууралт
1	Нээлттэй тендер шалгаруулалтын арга	61	42	19
2	Хязгаарлагдмал тендер	5	0	5
3	Харьцуулалтын аргаар	99	132	-33
4	Шууд худалдан авалт	26	18	8
	Нийт	191	192	1

Эндээс үзэхэд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулагддаг хөрөнгө оруулалтын ажил 19 ТАХ-ээр, Шууд худалдан авалтын аргаар 8 ТАХ-ээр тус тус багассан бол харин харьцуулалтын аргаар худалдан авах ажил 33 аар энэ онд нэмэгдсэн байна.

Аймгийн хэмжээнд худалдан авах ажиллагаагаар мэргэшсэн АЗ сертификатай 28 хүн орон нутгийн өмчийн газарт бүртгэлтэй байдаг байна.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47.4-д “ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас томилсон иргэн, ЗДТГ-ыг ажилтныг оролцуулна” гэж заасны дагуу холбогдох төлөөллийг оролцуулж үнэлгээний хороо байгуулсан байна.

Мөн хуулийн 47.6-д “ үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна” гэсэн зүйл заалтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

2016 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг www.shilendans.gov.mn, www.meps.gov.mn, www.e-procurement.mn гэсэн сайтуудад байшуулсан бол 2017 оноос эхлэн www.tender.gov.mn сайтанд төлөвлөгөө гүйцэтгэл үр дүнг мэдээлдэг болсон байна.

2.2 Гүйцэтгэчийг сонгон шалгаруулахдаа нэг ижил цаг хугацаанд 2 ба түүнээс дээш ажил олгож гүйцэтгүүлсэнээр зарим ажил чанаргүй хийгдсэн байна.

Худалдан авах ажиллагааны алба 2016 онд 192 ТАХ-ний 151-ыг цахим, 23 уламжлалт аргаар зохион байгуулсан байна.

НТШ-ын аргаар зохион байгуулсан 7, харьцуулалтын аргаар зохион байгуулсан 47 ажлын гүйцэтгэчийг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34 дүгээр зүйл /Гэрээ шууд байгуулах арга/-ийн дагуу шалгаруулж гэрээ байгуулсан нь нийт худалдан авалтын 28.1%-ыг эзэлж байна.

31 НТШ, 85 ХА-аар сонгосон худалдан авалт нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 29.1-т зааснаар шаардлага хангасан сайн тендерээр үнэлэгдэж гүйцэтгэчийг шалгаруулсан нь нийт худалдан авах ажиллагааны 60.4 %-ийг, 18 ШХА нь хуулийн 7.3-т зааснаар шууд гэрээ байгуулсан нь нийт худалдан авах ажиллагааны 9.4%-ийг тус тус эзэлж байна.

Худалдан авах ажиллагааны байгуулсан гэрээний хугацаа болон гүйцэтгэгч байгууллагын мэдээллээс үзэхэд ижил цаг хугацаанд 2 ба түүнээс дээш ажил гүйцэтгэсэн 17 аж ахуйн нэгж 5029.0 сая төгрөгийн ажлыг гүйцэтгэсэн байна. /Дэлгэрэнгүй жагсаалт хавсралт №2 /

Гүйцэтгэгч байгууллагын боловсон хүчний чадавхийг зөв үнэлээгүйгээс зарим ажил чанаргүй хийгдсэн байна. Тухайлбал:

- “Жинст хөдрөг” ХХК нь нийт 116.1 сая төгрөгийн 3 ТАХ-г гүйцэтгэсэнээс 14.9 сая төгрөгөөр гүйцэтгэсэн прокурорын газрын засварын ажил нь зураг төслийн дагуу хийгээгүй, зохиогчийн хяналт хэрэгжүүлэлгүй, ашиглалтанд орсоноор хийгдсэн ажлууд үр дүнгүй болж мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулах шаардлагатай болсон.

- “Сэхүүн чоно” ХХК нь төсөвт өртөг өндөр 2 барилгын ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан нь чанарын доголдолтой байна. Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн барилга болон гаднах тохижилтийн ажил, Өрхийн эрүүл мэндийн цогц барилгын ажлын зарим ажлууд чанаргүй хийгдсэн байх тул гүйцэтгэгч байгууллагад төлбөрийн акт болон албан шаардлага хүргүүлсэн.
- “УТООБ” ХХК нь 119.6 сая төгрөгийн 2 ТАХ-г гүйцэтгэсэнээс “Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн” цогцолборын барилгын тоног төхөөрөмжийг 85.3 сая төгрөгөөр ханган нийлүүлэхдээ тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, туршилт тохируулга хийж хүлээлгэн өгөөгүй, хөрөнгө ашиглалтгүй болсон байх тул албан шаардлага хүргүүлсэн.
- “Хуйвт уул” ХХК нь 223.3 сая төгрөгөөр 2 ТАХ-г гүйцэтгэсэнээс Байцааны /505 тн/ зоорьны барилгыг үргэлжлүүлэн барих 164.0 сая төгрөгийн ажил нь бүрэн ашиглалтанд хүлээлгэн өгөөгүй, гүйцэтгэгч байгууллагыг аймгийн ЗДТГ-ын хууль эрх зүйн хэлтэс шалгаж байна.

Тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулж буй үнэлгээний хороо нь ТБОНӨХБАҮХАТХ-н 6.1-т “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэж заасны дагуу өрсөлдөөний тэгш байдлыг бий болгож, гүйцэтгэгч байгууллагын боловсон хүчний чадавхийг бодитойгоор үнэлж, хөрөнгө оруулалтын ажил чанартай, үр дүнтэй болоход анхаарч, гүйцэтгэх ажил нь цаг хугацаа, хүний нөөцийн хувьд давхардах тохиолдолд тендерт оролцогчид 2 ба түүнээс ажил гүйцэтгүүлэхээр сонгон шалгаруулалт хийхгүй байх шаардлагатай байна.

2015 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 191 ТАХ-ний 63.8% буюу 122 ТАХ-нд орон нутгийн аж ахуйн нэгж, 20.8% буюу 40 ТАХ-нд бусад орон нутгийн байгууллага шалгарч байсан бол 2016 онд батлагдсан 192 ТАХ-ний 76.6% буюу 147 ТАХ-нд орон нутгийн аж ахуйн нэгж, 23.4% буюу 45 ТАХ-нд бусад орон нутгийн аж ахуйн нэгж байгууллага шалгарсан байна. Үүнийг графикаар харуулбал:



Худалдан авах ажиллагаанд шалгарсан орон нутгийн аж ахуйн нэгжүүд сүүлийн 2-3 жилд өссөн үзүүлэлттэй байна.

Орон нутгийн аж ахуйн нэгжийн боловсон хүчний чадавхийг үнэлж ажилчдаа нийгмийн даатгалын шимтгэлд бүрэн хамруулдаг эсэхийг зарим гүйцэтгэгч байгууллагын материалаас

дүн шинжилгээ хийхэд ихэнхи аж ахуйн нэгж захирал, нягтлан, ерөнхий инженер гэсэн 3-5 ажилтныг НДШ-д хамруулсан байна.

Энэ нь мэргэжлийн ажилтангүй, боловсон хүчний чадавхигүй аж ахуйн нэгж олширсон, гүйцэтгэсэн ажил чанаргүй болох, мэргэжлийн бус ажилчидаар ажил гүйцэтгүүлэх эрсдэл байгааг харуулж байна.

Барилгын хөгжлийн төвийн <http://barilga.gov.mn> сайтанд 2016 оны 9 дүгээр 22-ны байдлаар Орхон аймгийн харъяа барилгын ажил эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 173 аж ахуйн нэгж, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, засвар угсралт эрхлэх 12 аж ахуйн нэгж, зураг төслийн тусгай зөвшөөрөлтэй 9 аж ахуйн нэгж бүртгэлтэй байна.

ҮАГ санал:

Барилга хот байгуулалтын яамнаас Барилгын хөгжлийн төвөөр дамжуулан барилгын тусгай зөвшөөрөл, Эрчим хүчний яамнаас цахилгаан болон дулааны тусгай зөвшөөрлийг тус тус олгож байна.

Дээрх яамдуудад тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгахдаа гол мэргэжлийн ажилчид байгаа эсэх, тухайн ажигнуудын тогтвор суурьшилын талаар мэдээлэл судалгааг нарийвчлан авч байх талаар зөвлөмж хүргүүлэх саналтай байна.

2.3 Худалдан авах ажиллагааг зохион байгуулж, тайлагнасан хэдий ч тендерт оролцогч байгууллагын талаарх мэдээллийн сан хангалтгүй байна.

Худалдан авах ажиллагааны мэдээ тайлангаас үзэхэд 2 дугаар улирал буюу 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар худалдан авах ажиллагааны гүйцэтгэл 94.1%, 3 дугаар улирлын байдлаар 93.3% гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гүйцэтгэлийн мэдээ тайланг Сангийн яам болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт улирал бүр мэдээлсэн байна.

Мөн Авилгатай тэмцэх газарт худалдан авах ажиллагааны тайланг жил бүрийн 11 дүгээр сард хүргүүлдэг байна.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулдаг хугацаанаас үзэхэд:

- НТШ-ын журмаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад үнэлгээний хороо байгуулахад 1-2 хоног, ТББ боловсруулах, техникийн тодорхойлолт бэлтгэхэд 10 хоног, тендер зарлан мэдээлэхэд 30 хоног, үнэлгээ хийхэд 15-20 хоног, гэрээ байгуулах эрх олгоход 5 хоног, гэрээ хийж гарын үсэг зуруулахад 3 хоног нийтдээ 64-70 хоног буюу 2 сараас дээш хугацаа
- ХА-аар сонгон шалгаруулалт явуулахад үнэлгээний хороо байгуулахад 1-2 хоног, ТББ боловсруулах, техникийн тодорхойлолт бэлтгэхэд 10 хоног, тендер зарлан мэдээлэхэд 7 хоног, үнэлгээ хийхэд 15-20 хоног, гэрээ байгуулах эрх олгоход 5 хоног, гэрээ хийж гарын үсэг зуруулахад 3 хоног нийтдээ 41-47 хоног буюу 2 сар хүртэл хугацаа
- ШХА-т үнэлгээний хороо байгуулахгүй, гэрээ байгуулахад 3 хоног тус тус шаарддаг байна.

ХА болон НТШ-ын журмаар шалгаруулж буй ТАХ-нд 41-70 хүртэлх хоног зарцуулдаг нь төлөвлөгөөт ажил тохиромжтой хугацаандаа хийгдэхгүй байх, цаг хугацаа алдах зэрэг эрсдэлтэй байна.

Иймд Орон нутгийн өмчийн газар жил бүрийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахад ажил бүрээр зарцуулсан хоногийн судалгааг нарийвчлан гаргаж, аймгийн Засаг дарга болон ИТХ-д санал хүргүүлж төлөвлөлт хийхэд ажлын онцлог шинжийг харгалзан үзэж тухайн ажлын гүйцэтгэх улирлыг уялдаатай төлөвлөхөд анхаарч ажиллах шаардлагатай байна.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 51.1-т “Тендерт оролцогчдын хүрээг өргөжүүлэх, өрсөлдөөнийг дэмжих, захиалагчийг мэдээллээр хангах зорилгоор энэ хуульд заасан журмын дагуу худалдан авах ажиллагаанд оролцохыг сонирхогч хуулийн этгээд, иргэний бүртгэлийг холбогдох төрийн захиргааны төв байгууллага тухайн Засгийн газрын гишүүний эрхлэх хүрээний асуудлаар хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлнэ” гэж заасан боловч Орон нутгийн өмчийн газарт худалдан авах ажиллагаанд оролцдог аж ахуйн нэгжийн өмнөх үеийн түүх, тендерт оролцсон байдал, тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа, байгууллагын байршил, хийсэн ажлын гүйцэтгэлийн байдал, гэрээний үүргээ зөрчсөн эсэх, хөндлөнгийн хяналт шалгалтын дүгнэлт зэргийг агуулсан мэдээллийн сан үүсээгүй байна.

Иймд жил бүр оны эцэст холбогдох газруудаас тухайн жилийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын гүйцэтгэлийн мэдээлэлийг авч нэгтгэн мэдээллийн санг бүрдүүлж, тендерт оролцогчийн хүрээг өргөжүүлэн, өрсөлдөөнийг дэмжиж, захиалагчийг мэдээллээр ханган бүртгэлийн тогтолцоог сайжруулах тухай Орон нутгийн өмчийн газарт зөвлөмж хүргүүлээ.

2.4 Худалдан авах ажиллагаанаас бий болсон төсвийн хэмнэлтийг ерөнхий орлогын данс руу бүрэн төвлөрүүлээгүй нь Сангийн яамнаас эрх нээхдээ дутуу нээсэнтэй холбоотой байна.

Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйл “Төсвийн зарлагын хэмнэлт” 45.1.6-д ” төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээг хүрэх үр дүн чанарыг нь бууруулахгүйгээр илүү үр ашигтай, оновчтой хувилбараар зохион байгуулснаар бий болсон үлдэгдэл” гэж заасны дагуу төлөвлөсөн ажлаас үүссэн хэмнэлтийг харуулбал:

№	Ажлын нэр төрөл	Баталсан төсөв	Гэрээний дүн	хэмнэлт
1	Авто зам засвар шинэчлэлт	1247.2	1242.6	4.6
2	Инженерийн шугам сүлжээний засвар	2202.9	2024.5	178.4
3	Барилгын их засвар, шинэ барилга	14768.9	14012.1	756.8
5	Байгаль хамгаалах сан	520.0	357.8	162.2
7	Тавилга эд хогшил худалдан авах	2742.8	2673.7	69.1
	Нийт	21481.8	20310.7	1171.1

Уг хүснэгтээс үзэхэд батлагдсан төсвөөс 1171.1 сая төгрөгийн хэмнэлт байхаар харагдаж байна.

Үүнээс 2016 онд хэрэгжээгүй 9 ТАХ-ний 572.1 сая төгрөгийн гүйцэтгэл гараагүй, гэрээ байгуулан хэрэгжиж буй ТАХ-ээс 599.0 сая төгрөгийн хэмнэлт бий болсон байна.

Сангийн сайдын 2012 оны 290-р тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын зарцуулалтын журмын 3.26-д “Хөрөнгө оруулалтын ажлын тендер шалгаруулалтын дүнд бий болсон хэмнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч ашиглахгүй” гэж заасан байна.

Хөрөнгө оруулалтын хэмнэлт 599.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн эсэхийг хуулгаас үзэхэд Сангийн яамнаас хөрөнгө оруулалтын зардлын эрх нээхдээ 465.4 сая төгрөгөөр дутуу нээсэн, үлдэгдэл 133.6 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлого дансанд шилжүүлсэн байна.

Аймгийн СТСХ-т төсвийн хэмнэлтийн талаарх хөрөнгө оруулалтын зардлын судалгаа, Сангийн яамны эрх нээж өгсөнтэй холбоотой тоон үзүүлэлтийг хөтөлж мэдээлэл бэлтгэж, түүнээс гарах үр ашиг, үр дүн, үр нөлөөллийг дүгнэн нэгдсэн санхүүгийн тайлангийн тодруулгад оруулж байх шаардлагатай байх тул зөвлөмжөөр хүргүүлэв.

2.5 Худалдан авах ажиллагааны эрх шилжүүлсэн ТАХ орон нутагт байхгүй байна.

Төсвийн тухай хуулийн 6.6.3-т “ төсвийн захирагч нь өөрийн эрх, үүргээ доод шатны төсвийн захирагчид шилжүүлж болох боловч энэ нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй байх” гэж заасан.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ТАХ-нүүдэд сум болон төсвийн байгууллагууд руу эрх шилжиж хийгдсэн ТАХ байхгүй байна.

2.6 ТАХ-ний зориулалтыг ИТХ-ын тогтоолын дагуу өөрчилсөн, тоног төхөөрөмж нэрийн дор авто машин худалдан авч УИХ-ын тогтоолыг зөрчсөн байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулахдаа худалдан авах ажиллагааны мэргэжилтэн ИТХ-аар батлагдсан ТАХ-ны жагсаалтаас хөрөнгө оруулалтын шинж чанартай ажлыг түүн, жилийн төлөвлөгөөг гаргаж, байгууллагын даргаар хянуулан, ЗДТГ-т хүргүүлдэг байна.

ЗДТГ-ын холбогдох мэргэжилтэн хянаж нягтласаны дараа ЗДТГ-ын дарга Засаг даргад хүргүүлэн батлуулдаг байна.

Худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөөг шат бүрт тулган шалгаж хяналт хэрэгжүүлдэг тул ИТХ-аар батлагдсан хөрөнгө оруулалтын ажлын зориулалт өөрчлөх тохиолдол гараагүй байна.

Энэ онд аймгийн СТСХ-ээс ИТХ-д өргөн мэдүүлсэн хөрөнгө оруулалтын ТАХ-ний нэгдсэн дүн дүнгүүд нь барихгүй байх, өмнөх хурлаар баталсан дүнг дараагийн тогтоолд орхих зэрэг алдаа зөрчил гаргасан байна. Тухайлбал:

Аймгийн ИТХ-ын 2016 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор баталсан хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгагдсан 2 ТАХ нь аймгийн ИТХ-ын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан тодотгосон төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад зориулалт өөрчлөгдөн тусгагдсан. Үүнд:

- Их шүтээн цогцолборын ногоон байгууламжийн зориулалттай 10.0 сая төгрөгийн ажил Их шүтээн цогцолборын гол барилгын нүүр талыг металл хавтангаар өнгөлөх ажил болгон өөрчилсөн.
- ИШС-ний ажил хийгдсэн талбайн ногоон байгууламжийн нөхөн сэргээлт хийх 10.2 сая төгрөгийн ажлыг Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газарт тоног төхөөрөмж болгон тус тус өөрчилсөн байна.

Төсвийн тухай хуулийн 16.5.5-д заасан “ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчин 4 ТАХ-ний 125.0 сая төгрөгөөр бэлтгэсэн байна. Үүнд:

- Цагдаагийн газарт техник тоног төхөөрөмж худалдан авах 30.0 сая төгрөг батлагдсан бол land cruiser 200 маркийн авто машин худалдан авсан .
- ОБГ-т аврах эрэн хайх ажиллагааны механизм, тусгай техник тоног төхөөрөмж 45.0 сая төгрөг батлагдсан байхад land cruiser 200 маркийн авто машин худалдан авсан.
- Хүүхэд залуучуудын театрт тоног төхөөрөмж нийлүүлэх 25.0 сая төгрөг батлагдсан бол Старекс маркийн автомашин худалдан авсан байна.
- Аудитын газар тусгай техник тоног төхөөрөмж авах 25.0 сая төгрөг батлагдсан бол Toyota vanguard маркийн авто машин худалдан авсан байна.

Энэ нь МУ-ын УИХ-ын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай

47 дугаар тогтоолын 6-д “Төсвийн хөрөнгөөр автомашин шинээр худалдан авахгүй байх” гэсэн зүйл заалтыг зөрчсөн байна.

Иймд хөрөнгө оруулалтаар хийгдэх ТАХ-г батлахдаа хууль журамд нийцүүлэн ТАХ-ний зориулалт нэрийг нягтлан шалгаж байх, тайлант жилд хэрэгжих төсөл хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг бодитоор үнэлж төсөвт тусгах тухай зөвлөмжийг ИТХ, СТСХ-д хүргүүллээ.

Бүлэг 3: Гүйцэтгэгчтэй байгуулсан хэлцлийн гэрээний зарим зүйл заалт тодорхойгүй, зохиогч ба захиалагчийн хяналт хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

3.1 Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний зарим зүйл заалт тодорхойгүй, оновчтой бус байна.

Аудитад хамрагдсан ажлуудаас зориулалт бус зарцуулсан 5 ТАХ-ний 701.4 сая төгрөг, зах зээлийн үнээс өндөр үнээр бэлтгэгдсэн 6 ТАХ-ний 472.6 сая төгрөг, гэрээнд тусгагдсан гүйцэтгэх хугацаа тохиромжгүй 6 ТАХ-ний 312.4 сая төгрөг, үр дүн тодорхойгүй 22 ТАХ-ний 2283.4 сая төгрөг, бүрэн нийлүүлэгдээгүй 2 ТАХ-ний 76.5 сая төгрөг, чанарын доголтой 32 ТАХ-ний 5924.6 сая төгрөг, Зураг төслийн дагуу хийгдээгүй 2 ТАХ-ний 113.5 сая төгрөг нийт 75 ТАХ-ний 9850.4 сая төгрөгийн ажлуудад зөрчил дутагдал илэрсэн нь нийт хөрөнгө оруулалтын ажлын 40%-ийг эзэлж байна. /Дэлрэнгүйг хавсралт №01/

Хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барилгын ажил гүйцэтгэх гэрээг захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан хэлцлийн гэрээ нэртэйгээр хийж аймгийн Хуулийн хэлтсийн дарга хянаж, Засаг даргаар батлуулсанаар хүчин төгөлдөр болж байна.

Тус гэрээнд 9 төрлийн зүйл заалтыг тусгасан бөгөөд үүнээс дараах зүйл заалтад тодорхой нэмэлт оруулах шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

- Гэрээний 4.10-т “Чанарын баталгаат хугацаа 3 жил байна” гэж заасан. Гэвч зарим гэрээнд чанарын баталгаат хугацааг 1 жил байхаар тусгасан байна. Иймд хөрөнгө оруулалтын шинж чанар, мөнгөн дүнгээс хамаарч ямар ажилд 1 жилийн баталгаа, ямар ажилд 3 жилийн баталгаат хугацаатай байхыг тодорхой шийдэж гэрээнд тодорхой тусгах
- Гэрээнд хийж гүйцэтгэх ажлын нэр тусгагдсанаас, юу хийх талаар огт тусгагдаагүй байна. Иймд техникийн тодорхойлолт, төсөвт тусгагдсан ажлын тоо хэмжээг гэрээний хавсралт хэлбэрээр оруулах шаардлагатай байна.
- Мөн байгуулсан хэлцлийн гэрээнд хугацаандаа гэрээт ажлаа хүлээлгэн өгөөгүй тохиолдолд гэрээний дүнгээс хэдэн хувиар тооцож алданги ноогдуулах талаар тодорхой зүйл заалт тусгаагүй байна. Иймд хугацаа хэтэрсэн тохиолдолд хэдэн хувийн алдангийг хэрхэн тооцож суутгах талаар тодорхой тусгах шаардлагатай.
- Барилга барих, засварын ажлуудын чанар тодорхой хугацааны дараа мэдэгдэж байгаатай холбогдуулж санхүүжилтийн хэмжээнээс үл хамааран баталгааны 5%-ийг зайлшгүй авч үлдэх талаар тодорхой заалт оруулж өгөх шаардлагатай байна.

Иймд гэрээнд өөрчлөлт оруулах, гэрээний зүйл заалтыг тодорхой, боловсронгуй болгох талаар холбогдох байгууллагуудад зөвлөмжөөр хүргүүлэв.

Хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудаас 18 ТАХ гэрээт хугацаанаасаа хэтэрч хугацааны алдангийг нийт санхүүжилтээс нь хасч олгосон байна.

Түүнчлэн ил далд ажлын акт үйлдсэн он сар өдрүүд, барилга байгууламжийн урьдчилсан үзлэгийн комиссын актын бичилт, комиссоос өгсөн үүрэг, түүнийг биелүүлэх хугацаа, улсын комиссын хурлын протокол дээрх огноо, өгсөн үүрэг, түүнийг биелүүлэх хугацаа, барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комиссын гишүүний санал өгсөн огноо, барилга

байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын актын дугаар, огноо, бичилт зэрэг нь бодит байдалтай нийцэхээргүй, тухайн гүйцэтгэгч яг хэдийд захиалагчид хүлээлгэн өгснийг тодорхойлох боломжгүй, харилцан уялдаагүй байгаа нь хугацаа хоцорсон эсэх, хугацааны алдангийг бодитой тооцох боломжийг хаагдуулсан байна.

Тиймээс гэрээт ажил дууссан хугацааг Өмчийн газарт хүлээлгэн өгсөн хугацаагаар тооцож байх шаардлагатай байна.

Мөн өмнөх аудитаар ажлын чанар болон үзэмжийг хангалтгүй байхад санхүүжилт олгох, гүйцэтгэлийг баталгаажуулж байгаад анхаарах, чанаргүй хийгдсэн ажлаас болж хийгдсэн хөрөнгийн ашиглах хугацаа богино болох, улмаар төсвөөс дахин засварлах зардал гарсаар байгааг засах, сайжруулах, хяналт тавих ажлыг сайжруулах талаар ХББЗА ОНӨҮГ-т албан шаардлага хүргүүлсэн.

Гэвч дээрх алдаа дахин давтан гарч байгаа тул хяналт хэрэгжүүлэх, улсын комиссын бүрэлдэхүүнд орж ажиллахад баримтлах арга зүй, үйлдэх баримт, мэдээллийг тодорхой болгох талаар арга хэмжээ авч, ажилтны хариуцлага сахилга батыг сайжруулах, гүйцэтгэсэн ажлын үр дүнг дүгнэх тухай ХББЗА ОНӨҮГ-т албан шаардлага хүргүүлээ.

3.2 Хөрөнгө оруулалтын ажил нь төлөвлөлт оновчгүй, ашиглагч байгууллагаас шалтгаалан зориулалт бус зарцуулагдсан байна.

Шалгалтанд хамрагдсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнээс 20.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 2 ТАХ ашиглагч байгууллагаас шалтгаалан нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж зориулалтын дагуу зарцуулагдаагүй байна. Тухайлбал:

- Баян-өндөр суманд төрийн сангийн нэгж байгуулах, тоног төхөөрөмж худалдан авах /10.0 сая төгрөг/. Нийлүүлсэн тоног төхөөрөмжийн ашиглалт хангалтгүй, сумын бүртгэлээр тавих хяналт хангалтгүй, хөрөнгийг төрийн сангийн нэгжид ашиглуулаагүй, сумын ЗДТГ болон багуудад хуваан ашиглаж байна.
- “Шилэн дансны тухай хууль”-ийг орон нутагт хэрэгжүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж /10.0 сая төгрөг/. Санхүүгийн хяналт дотоод аудитын албанд нийлүүлсэн тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлагагүй хөрөнгийг захиалсан.

Мөн зориулалтын дагуу зарцуулсан боловч үндсэн зорилгоо хангаагүй, үр дүн тодорхойгүй хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн байна. Үүнд:

Орхон аймаг 29000 айл өрхтэй үүний 16000 нь гэр хороололд амьдардаг. Аймгийн баруун дээд хэсэгт гэр хороолол төвлөрдөг, Монголын салхи баруунаасаа зүүн зүг рүү чиглэдэг тул утаа нь ямар ч саадгүй Эрдэнэт хотыг бүрхдэг.

Хот төлөвлөлт нь баруун талаараа гэр хорооллын суурьшлын бүстэй учир утаа “үйлдвэрлэж” буй 16000 эх үүсвэрт чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн.

Өмнөх он буюу 2015 онд Гэр хорооллын айл өрхүүдийг цахилгаан халаалтанд шилжүүлэх ажлын хүрээнд цахилгааны 2 тарифт тоолуур тавихад хөнгөлөлт үзүүлэх ажилд 200.0 сая төгрөг зарцуулахаар гэрээ байгуулан гүйцэтгэсэн байна.

Байгаль хамгаалах сангаас 2016 онд хийгдэх хөрөнгө оруулалтын 3 ТАХ-нд 520.0 сая төгрөг төлөвлөж, 3 ТАХ-г 357.8 сая төгрөгөөр /Агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх, Гэр хорооллын хязгаарлалтын бүсээс хамааруулан айл өрхүүдэд сайжруулсан зуухны хөнгөлөлт үзүүлэх /татаас// хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан байна.

Дээрх хөрөнгө оруулалтыг хийхдээ Цахилгааны 2 тарифт тоолуурыг хөнгөлөлттэй үнээр айл өрхийг хангах улмаар шалны халаалт тавиулах, халаалт тавигдсан айл өрхөд

шингэрүүлсэн шатдаг хийн зуух хөнгөлөлттэй олгож утаа гаргах яндангийн тоог цөөлөх замаар агаарын бохирдлыг өвлийн улиралд бууруулах зорилт тавьсан.

Цахилгааны 2 тарифт тоолуур нь Дэнж, Эрдэнэ, Баянцагаан, Говил багт суурилуулагдсан, харин Их залуу, Даваат, Яргуйт, Шанд багийн 706 иргэн хүсэлт өгсөн боловч ЭБЦТС ТӨХК-аас цахилгааны дэд станцууд хүчин чадлаа дийлэхгүй гэдэг шалтгаанаар холбогдоогүй байна.

Харин бүрэн шаталттай сайжруулсан, шингэрүүлсэн шадтаг хийн зуухыг олгохдоо Шанд, Даваат, Яргуйт, Их залуу, Дэнж, Эрдэнэ багийн 728 иргэнд олгосон байна.

Агаарын бохирдлын бууруулах төлөвлөгөөний гол зорилго нь 2 тарифт тоолуур болон шингэрүүлсэн, шатдаг хийн зуух хоёр нэг дор байршсанаар гэр хорооллын утаа тодорхой түвшинд багасахаар байтал 2 тарифт тоолуур суурилагдаагүй газарт хийн зуух борлуулсан нь оновчтой бус, үр дүн тодорхойгүй хөрөнгө оруулалт болж үндсэн зорилгоо биелүүлээгүй зориулалт бус байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2016 онд гүний худаг лайдаж ухаалаг төхөөрөмж суурилуулах 5 ТАХ-нд 659.0 сая төгрөг зарцуулж аймгийн Засаг даргатай ОР-142/2016, БЗА-49/16, БЗА-23/16, БЗА 22/16 тоот гэрээг байгуулсан байна.

Мөн Баян-өндөр сумын ОНХС-аас 84.6 сая төгрөгийн ус түгээх 6 байранд автомат төхөөрөмж суурилуулах ажлыг Алтайн үндэс ХХК сумын Засаг даргатай БӨ-16-Б/36 тоот гэрээ байгуулан гүйцэтгэсэн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн “Гэр хорооллын ус түгээх байруудад ухаалаг төхөөрөмж суурилуулах, нэгдсэн хяналт, удирдлагын системд холбох / 38ш/”, “ Дэнж, Яргуйт багт ухаалаг төхөөрөмжтэй ус түгээх байр барих /гүний худагтай/”, “Говил , Баян цагаан баг, Вокзалд ус түгээх байрны гүний худгийг лайдаж ухаалаг төхөөрөмж суурилуулах” ажлуудад гүйцэтгэгч байгууллагууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн, ажлыг хийж гүйцэтгэн, хүлээлгэн өгөхдөө ухаалаг төхөөрөмжийн хэрэглэгчийн 11700 ширхэг картыг нэг бүр нь 3716 төгрөг , нийт 43.5 сая төгрөг, 3000 ширхэг картыг 5000 төгрөгийн өртгөөр нийт 15.0 сая төгрөг, Баян-өндөр сумын орон нутгийн хөгжлийн сангаас хийсэн ажилд 1800 картыг 5000 төгрөгийн өртгөөр нийт 9.0 сая төгрөг, нийтдээ 16500 ширхэг 67.5 сая төгрөгийн картыг “Эрдэнэт-Ус ДТС” ОНӨХК-д хүлээлгэн өгсөн байна.

Тус байгууллага энэхүү картыг эргэлтийн хөрөнгөд бүртгэн хэрэглэгчдэд борлуулж, 28.1 сая төгрөгийн орлогыг өөрийн дансанд төвлөрүүлж, үлдэгдэл 39.4 сая төгрөгийн 9719 ширхэг картын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т “ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн зүйл заалтыг зөрчих тул Хөрөнгө оруулалтын шинж чанартай хийгдсэн ажлаас хэрэглэгчийн картны төлбөр 67.5 сая төгрөгийг орон нутгийн хөрөнгө оруулалтын дансанд төвлөрүүлэх тухай “Эрдэнэт-Ус ДТС” ОНӨХК-д албан бичгээр хүргүүлээ.

Түүнчлэн Баян-Өндөр гудамжны баруун талд хийгдэх ногоон байгууламжийн /5-р хороолол/ ажилд 53.4 сая төгрөг, Баян-Өндөрийн гудамжинд ногоон байгууламжийн ажил шинээр хэсэгчлэн хийх /Согоот баг 6-р хороолол/ 24.4 сая төгрөг, нийт 2 ТАХ-ны 77.8 сая төгрөгийн ажлыг Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар гүйцэтгэн, санхүүжилтийг тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд бүрэн шилжүүлсэн байна.

Дээрх 2 ТАХ-ний ажлын гүйцэтгэл болон санхүүжилтийг зарцуулсан байдал нь аудитын цаг хугацаанд бүрэн хамрагдаагүй тул эрсдэлтэй гэж үзэж эрсдлийн аудитаар хийж гүйцэтгэн үнэлэлт дүгнэлт өгөх шаардлагатай гэж үзлээ.

3.3 Дуусаагүй хөрөнгө оруулалтын ажилд гүйцэтгэлийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Аудитад хамрагдсан ТАХ-ээс ажлын гүйцэтгэл дутуу, хангалтгүй бүрэн дуусаагүй 2 ТАХ-нд 76.5 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна. Үүнд:

- Биеийн тамирын спортын газарт тоног төхөөрөмж нийлүүлэх 8.5 сая төгрөгийн ажлыг Орхон аймгийн тэшүүрийн холбоо нийлүүлэхдээ гүйлтийн цана 1ш, тэшилтийн цана 3ш нийт 4.0 сая төгрөгийн техник хэрэгслийг дутуу нийлүүлсэн.
- Малын усны хангамжийг сайжруулах зорилгоор Баян-өндөр суманд 1 худаг шинээр, 5 худаг сэргээн засварлах, Жаргалант суманд 1 худаг шинээр, 3 худаг сэргээн засварлах ажлыг Хөвсгөд ундарга ХХК 68.0 сая төгрөгөөр гүйцэтгэхдээ Жаргалант сумын бөөн бургастад тариалан эрхлэгчдийн ундны ус, жимсний талбай услах зориулалттай 1 худаг шинээр гаргах 14.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг огт хийгээгүй, санхүүжилт бүрэн авсан.

Дээрх 2 ТАХ-г гүйцэтгэгч байгууллагад хариуцуулан төлбөрийн акт тогтоосон болно.

/Дэлгэрэнгүйг хавсралт №01/

Орхон аймгийн тэшүүрийн холбоо, Биеийн тамирын спортын газарт нийлүүлсэн тоног төхөөрөмжийн ажлын гүйцэтгэлд Тэшүүрийн холбооны техник хэрэгсэл нийлүүлэх тухай 16/01 албан бичиг, нэхэмжлэх, хүлээн авсан комиссын акт, БТСГ-ын 2016 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн 28, 29 дугаар албан бичиг, Орон нутгийн өмчийн газрын 2016 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн 50 дугаарын албан бичгийг тус тус үндэслэн санхүүжилт олгосон байна.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэс хөрөнгө оруулалтын санхүүжилтийг олгохдоо зарим нэг төлбөрийн хүсэлтэд үндэслэх бичиг баримтын нэрийг бүтэн оруулахгүй байгаа нь хэрэглэгчийг шаардлагатай мэдээллээр хангахад бэрхшээл учирхаар байна.

3.4 Томоохон барилга байгууламжийн төсөв хийхдээ нэгдсэн төсөв хийж түүнийгээ хэсэгчлэн жижиглээгүйгээс ажлын тоо хэмжээ давхцах, хийгдсэн ажил дараагийн төсөвт орох эрсдэл үүссэн байна.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоолоор Цагдаагийн газарт тоног төхөөрөмж худалдан авах 30.0 сая төгрөг батлагдаж иргэнтэй гэрээ байгуулан нийт 85.0 сая төгрөгийн автомашиныг худалдан авсан байна.

Үлдэгдэл санхүүжилт болох 55.0 сая төгрөг нь 2017 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан байна.

Энэхүү автомашины нийт өртөг нь 85.0 сая төгрөг байтал худалдан авах ажиллагааг тухайн оны төлөвлөгөөнд тусгагдсанаар харьцуулалтын аргаар зохион байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.2-т “ Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа ажил үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ” , 8.5-т “ Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэд тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэсэн зүйл заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Худалдан авах ажиллагааны журмыг сонгохдоо ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу нийт төсөвт өртгийг үндэслэл болгох шаардлагатай байна.

Түүнчлэн “Сэхүүн чоно” ХХК-ийн гүйцэтгэсэн Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн цогц барилгын зураг байгаа хэдий ч нэгдсэн нэг төсөв хийгдээгүй, 2014 оноос уг барилгын ажил эхлэн, тухайн жилд хийгдэх ажлыг жижиглэж хэсэгчилсэн байдлаар төсөв хийж он дамжин явсаар 2016 онд уг ажил дууссан байна.

Энэ нь ажлын тоо хэмжээ давхцах, хийсэн ажлыг дараагийн төсөвт дахин оруулах зэрэг эрсдэл байхаар байна.

Иймд томоохон барилга байгууламжийн ажлын төсвийг нэгдсэн нэг төсөв хийж, түүнийгээ тухайн оны төсвийн байдлаас шалтгаалан хэсэгчлэн хувааж, ажил давхцаж орсон эсэхийг тулган шалгаж байх шаардлагатай байна.

3.5 ТАХ-ний хэрэгжилтэд зохиогчийн болон захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэнээс чанаргүй ажлын тоо өссөн байна.

Захиалагчийг төлөөлж орон нутгийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨҮГ хяналт хэрэгжүүлдэг.

Мөн Хотын захирагчийн алба хөрөнгө оруулалтын явцын хяналтыг давхар хянасан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн ТАХ-г түүвэрлэн шалгахад дараах зөрчил илэрлээ.

- Барилгын засвар үйлчилгээнд ашиглаж байгаа зарим материалын чанарт захиалагчийн зүгээс тавих хяналтыг хангалтгүй гүйцэтгэсэн, хийгдээгүй ажлын гүйцэтгэлийг хянаж баталгаажуулан, санхүүжилт олгосон. Тухайлбал:
 - *Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн гол барилга*
 - *Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн хөшөө дурсгал, уран бүтээлийн ажил*
 - *Малын усны хангамжийг сайжруулах зорилгоор Баян-өндөр суманд 1 худаг шинээр, Жаргалант суманд 1 худаг шинээр барих ажил*
 - *Биеийн тамир спортын газарт тоног төхөөрөмж нийлүүлэх*
- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2 ТАХ-нд зохиогчийн болон захиалагчийн хяналтыг хангалтгүй хийснээс чанаргүй ажил хийгдэж зарим нь МХГ-ын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулах шаардлагатай болсон байна. Тухайлбал:
 - *Аймгийн Прокурорын газрын засвар*
 - *Оюут багийн 2-8,2-9,2-10,2-11-р байрны дундах тоглоомын талбай тохижуулах ажил*
- Зураг төслийг газар дээр нь очиж хэмжилт хийгээгүйгээс АТП 280, 0.4кв-н агаарын шугам болон МОН 2301 төслийн цэвэр усны шугамыг дайруулан тохижилтын ажил хийгдсэн байна. Тухайлбал:
 - *Амралт чөлөөт цагийн талбай байгуулах /Шанд баг/*

Дээрх алдаа зөрчлүүд нь Сангийн сайдын 2012 оны 290-р тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалт санхүүжилтийн журам”-ын 3.3-т “Захиалагч байгууллага төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын батлан гаргасан норм, норматив дүрэм болон тухайн барилгын ажлын төлөвлөгөөг үндэслэн ажил нэг бүрээр тулган баталгаажуулна”, 4.2-т “Захиалагч барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч ажиллана”, Барилга захиалагчийн дүрмийн 3.1.6-т “Мэргэжлийн хяналтын болон эрх бүхий байгууллагаас хийсэн үзлэг, шалгалтын дүн, техникийн дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, зөрчил, дутагдлыг арилгуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Мөн Орон нутгийн өмчийн газрын хөрөнгийн бүртгэл хөтлөлтөд дараах алдаа зөрчил илэрлээ. Үүнд:

- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 153.3 сая төгрөгийн 2 ТАХ-ний хөрөнгийг ашиглагч байгууллага санхүүгийн тайлан бүртгэлд тусгаагүй. Тухайлбал:
 - ✓ Хөх Монгол цогцолбор 85.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж
 - ✓ Малын усны хангамжийг сайжруулах зорилгоор Баян-өндөр суманд 1 худаг шинээр, 5 худаг сэргээн засварлах, Жаргалант суманд хийгдсэн 1 худаг шинээр, 3 худаг сэргээн засварлах 68.0 сая төгрөг
- Худалдан авсан хөрөнгийг хүлээж авахдаа гэрээнд заагдсан суурилуулт, туршилт тохируулгыг хийгээгүй байхад актаар хүлээн авч, санхүүжилтийг олгосоноос зарим тоног төхөөрөмж одоо болтол ашиглагдах боломжгүй байна. Тухайлбал:
 - ✓ Баян-Өндөр сумын багуудыг дохиолол хамгаалалтын системд холбох
 - ✓ Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн 5D кино театрын тоног төхөөрөмж / ашиглах зааварчилгаа өгөөгүй, цахилгааны эх үүсвэрийн холболтыг шийдээгүй, суурилуулалт хийгдээгүй байхад хүлээн авсан акт үйлдсэн/
 - ✓ Гэр хорооллын ус түгээх байруудад ухаалаг төхөөрөмж суурилуулах, нэгдсэн хяналт, удирдлагын системд холбох / 38ш/
- Орон нутгийн өмчийн газарт өмнөх оны хөрөнгө оруулалтын аудитаар “хөрөнгөө санхүүгийн бүртгэл тайландаа тусгаагүй байгууллагуудад уг хөрөнгийг бүртгэх талаар материалыг хүргүүлэх, бүртгэлд тусгасан эсэхийг хянаж баталгаажуулах” гэсэн зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжилт хангалтгүй зөрчил давтагдсан.
- “Тусгай зориулалтын, нарийн мэргэжлийн оношилгоо, дүрс бичлэгийн тоног төхөөрөмжүүдийг хөрөнгөнд бүртгэхдээ туршилт, тохируулга хийсэн баримтыг хавсаргаж, тухай бүрд нь хөрөнгөнд бүртгүүлэх албан бичгийг ашиглагч байгууллагад хүргүүлж байх” гэсэн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй зөрчил давтан гарсан байх тул зөрчил арилгах албан шаардлагыг хүргүүлээ.
- Орон нутгийн өмчийн ашиглалтын талаарх судалгааг ахлах мэргэжилтэнээс аудитын явцад шаардсан боловч аудитын багт ирүүлсэнгүй.

Орон нутгийн өмчийн газарт хөрөнгийн бүртгэл хөтлөлт, ашиглалтанд хяналт хэрэгжүүлж ажиллах, өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжүүдийн хэрэгжилт хангалтгүй, зөрчил давтан гарсан байх тул албан шаардлага хүргүүлэв.

3.6 Хэрэгжиж дууссан ТАХ-г улсын комисс хүлээж аваагүй, улсын комиссын акт гараагүй байхад санхүүжилт олгож ашиглалтад оруулсан ТАХ байхгүй байна.

Сангийн сайдын 2012 оны 290 тушаалаар баталсан Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журмын 3.5-д “Сангийн яамны төсвийн бодлогын асуудал хариуцсан нэгжийн мэргэжилтэн нь энэхүү журмын нэг болон хоёр дугаар хавсралтаар батлагдсан “хяналтын хүснэгт” нд тусгагдсан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг ажлын 2 хоногийн дотор дараах материалыг үндэслэн хянаж санхүүжүүлнэ”, 3.5.7-д “Барилга байгууламж их засварын ажлыг ашиглалтад хүлээн авсан тухай улсын комиссын акт, техникийн комиссын акт, тоног төхөөрөмж хүлээн авсан акт” гэж заасан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ-ээс улсын комиссын акт гараагүй байхад санхүүжилт олгож ашиглалтад оруулсан ТАХ байхгүй байна.

3.7 Хөрөнгө оруулалтын ТАХ-ний үр дүн тодорхойгүй, чанарын доголдолтой ТАХ нэмэгдсээр байна.

Аудитаар нийт хөрөнгө оруулалтын ажлаас Байгаль хамгаалах сангийн 337.8 сая төгрөгийн 2 ТАХ, Барилгын их засварын ажлын 13642.7 сая төгрөгийн 86 ТАХ, инженерийн шугам сүлжээний өргөтгөлийн 2538.2 сая төгрөгийн 24 ТАХ, Худалдан авсан тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын 972.6 сая төгрөгийн 27 ТАХ, Авто зам засвар шинэчлэлтийн 749.0 сая төгрөгийн 7 ТАХ нийт 18240.3 сая төгрөгийн 146 ТАХ, нийт хөрөнгө оруулалтын 53%-ийг хамруулан шалгалаа.

Үүнээс шалгалтаар 9850.4 сая төгрөгийн 75 ТАХ ямар нэгэн зөрчил доголдолтой байгаа нь аудитад хамрагдсан хөрөнгө оруулалтын ажлын 51.4% эзэлж байна.

Шалгалтанд хамрагдсан ТАХ-ээс 2283.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 22 ТАХ-ний үр дүн тодорхойгүй ажилд хөрөнгө оруулалт хийсэн байна. */Дэлгэрэнгүй хавсралт №01/*

Үр дүнгүй хөрөнгө оруулалтын шалтгаан нөхцөлүүдийг үзвэл:

- Хийгдсэн хөрөнгө оруулалтын ажилтай холбоотойгоор холбогдон гарах зардлыг шийдвэрлээгүй.
- Техник хэрэгслийг хангалттай иж бүрэн суурилуулж хүлээлгэж өгөөгүйгээс ашиглалт хангалтгүй.
- Говил багт баригдаж буй бохир усны цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн ажлын үлдэгдэл санхүүжилт улсын төсвөөс батлагдаагүй, хэзээ ашиглалтанд орох нь мэдэгдэхгүй байхад хөрөнгө зарцуулсан.
- Ашиглагч байхгүйгээс хөрөнгө үр ашиггүй болсон.
- Хийсэн ажлын чанар хангалтгүй, хийгдсэн ажил буруу байршилд хийгдсэнээс ашиглалтгүй хөрөнгө бий болсон.

Мөн аудитад хамрагдсан ажлуудаас 5924.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 32 ТАХ чанарын доголтой, ашиглалтын шаардлага хангахааргүй гүйцэтгэгдсэн байна. */Дэлгэрэнгүй хавсралт №01/ Тухайлбал:*

- Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн цогцолборын барилгыг барих ажлыг “Сэхүүн чоно” ХХК 2014-2016 онд нийт 1682.7 сая төгрөгийн өртгөөр гүйцэтгэн нийт санхүүжилтээс 1600.5 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн авсан байна. Хийгдсэн ажлуудаас 48.7 сая төгрөгийн ажил чанарын шаардлага хангахгүй байна.
- Малын усан хангамжийг сайжруулах зорилгоор Баян-Өндөр суманд 1 худаг шинээр, 3 худаг сэргээн засварлах, Жаргалант суманд 1 худаг шинээр, 5 худаг сэргээн засварлах ажлын захиалагч, гүйцэтгэгчийн хооронд 2016 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр байгуулсан БЗА-54/16 тоот хэлцлийн гэрээний дагуу Жаргалант сумын Жаргалант багийн Бөөн бургаст 104/24/88.3; 49/02/29.8 солбилцол бүхий талбайд тариалан эрхлэгчдийн ундны ус, жимсний талбай услах зориулалтаар шинээр гаргах 1 худаг 14.1 сая төгрөгийн төсөвт өртгөөр хийгдэх ажил огт хийгдээгүй, хуурамч материал бүрдүүлэн санхүүжилт бүрэн авсан.
- Оюут багийн 2-8, 2-9, 2-10, 2-11 дүгээр байрны дундах тоглоомын талбай тохижуулах ажлын захиалагч, гүйцэтгэгчийн хооронд 2016 оны 6 дугаар сарын 9-ний өдөр байгуулсан БЗА-134/16 тоот хэлцлийн гэрээний дагуу тоглоомын талбай тохижуулах ажлаас 23.7 сая төгрөгийн ажлыг чанаргүй гүйцэтгэсэн.
- Орхон аймгийн тэшүүрийн холбоо нь 2016 оны 03 сард Биеийн тамир спортын газарт өвлийн спортын тэмцээн уралдаанд шаардлагатай 6 ширхэг цана, 5 ширхэг тэшүүрийг 8500.0 мянган төгрөгөөр нийлүүлэхдээ 4000.0 мянган төгрөгийн тоо

ширхэг дутуу, иж бүрдэл хангалтгүй, санхүүжилтийн анхан шатны баримтыг хуурамчаар үйлдэн санхүүжилтыг бүрэн авсан

Дээрх хэрэгжилт хангалтгүй, чанаргүй гүйцэтгэсэн 4 ТАХ-нд нийт 90.5 сая төгрөгийн төлбөрийн актыг гүйцэтгэгч байгууллагад хариуцуулан тогтоов.

- ❖ Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн цогцолборын хөшөө дурсгал уран бүтээлийн ажлыг 373.2 сая төгрөгөөр Их материал ХХК гүйцэтгэсэн боловч хийгдсэн 21 аймгийн онцлог зүйлсийг харуулсан уран бүтээлийн ажил хуурч ховхорсон, үзэмж муутай болсон
- ❖ Говил багийн 37 айлын орон сууц, ЭҮ-н цагдаа орчмын үерийн хамгаалалтын сувгийг Жавхлан харгуй ХХК 63.3 сая төгрөгөөр гүйцэтгэхдээ хийгдсэн цутгамал хоолой хүйтний улиралд хийснээс шалтгаалж хуурч үйрсэн, шүүлтүүр металл решётка авто машины даац даахгүй эвдэрсэн.
- ❖ Баян-Өндөр сумын багуудыг дохиолол хамгаалалтын системд холбох ажилд орон нутгийн төсвийн хөрөнгөөс 30.0 сая төгрөг, Баян-Өндөр сумын орон нутгийн хөгжлийн сангаас 43.6 сая төгрөг нийт 73.6 сая төгрөг зарцуулж 21 багт хөдөлгөөн мэдрэгч, утаа мэдрэгч багийн өрөөнүүдэд камер, Баян-Өндөр сумын Тамгын газрын даргын өрөөнд хяналтын нэгдсэн дэлгэцийг тус тус байрлуулсан байна. Багууд дээр байрлуулсан хяналтын дэлгэцүүд бүрэн суурьлагдаагүй, хамгаалалтын хайрцагт байрлуулаагүй, 21 багийг хянах нэгдсэн дэлгэц нь одоогоор ажиллаагүй, хүлээлгэн өгөхдөө туршилт тохируулга хийгээгүй, гэрээт ажлыг бүрэн дуусгаагүй байхад акт үйлдэж, санхүүжилт олгосон.
- ❖ Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газрын Өвлийн хүлэмжид өргөтгөл хийх /ажилчдын амрах байр/ барих ажлыг 34.2 сая төгрөгийн өртгөөр хийж гүйцэтгэн, хүлээлгэн өгсөн боловч складны өрөөний дээврийн дулаалга муу хийгдсэнээс цан цохисон, шалны хулдаас чанаргүй, нимгэн хулдаас нааснаас шалтгаалан хуурсан, урагдсан гэх мэт нийт 3.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг чанаргүй хийж гүйцэтгэсэн.
- ❖ Өрхийн эрүүл мэндийн цогц төв барих ажлын захиалагч, гүйцэтгэгчийн хооронд 2016 оны 6 дугаар сарын 7-ны өдөр байгуулсан БЗА-130/16 тоот хэлцлийн гэрээний гүйцэтгэлээр нийт 1074.2 сая төгрөгийн санхүүжилт авахаас 1012.8 сая төгрөгийг авч 61.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. 14.2 сая төгрөгийн ажил чанаргүй гүйцэтгэсэн.
- ❖ "Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн" цогцолборын барилгын тоног төхөөрөмж 85.3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн байдал хангалтгүй, бүрэн ашиглалтгүй, 5d кино театрын сандлыг ажиллуулах моторыг байрлуулах газрыг шийдээгүй, тоног төхөөрөмжийг байрлуулахдаа бүрэн суурилуулж шийдвэрлээгүй.

Дээрх 6 ТАХ-нд 613.3 сая төгрөгийн албан шаардлагыг гүйцэтгэгч байгууллагад хариуцуулан хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Хөрөнгө оруулалтын төлөвлөлт оновчгүй, техникийн ерөнхий шийдэл, зураг төслийн даалгавар, захиалагчийн хяналт хангалтгүй хийгдсэнээс үр ашиггүй, чанаргүй, үр дүн тодорхойгүй хөрөнгийн тоо өссөн байна.

Дээрх дүгнэлтэд үндэслэн гүйцэтгэгч байгууллагад 90.5 сая төгрөгийн 4 төлбөрийн акт, 613.3 сая төгрөгийн 6 албан шаардлагыг хүргүүлж, Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ХББЗА ОНӨҮГ-т зөрчил арилгах 1 албан шаардлага, Орон нутгийн өмчийн газарт хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 153.3 сая төгрөгийн 1 албан шаардлагыг тус тус хүргүүлж дараах зөвлөмжүүдийг холбогдох байгууллагуудад тайлангаар хүргүүлж, “Эрдэнэт-Ус ДТС” ОНӨХК-д албан бичгээр зөвлөмжийг тус тус хүргүүлж байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн ИТХ-д:

- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зориулалт, нэрийг нягтлан шалгаж байх
- Аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн хөрөнгө оруулалтын төсвийг хянах боломжтой цаг хугацааг тогтоон мөрдүүлэх, барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээний төсвийг нэг дүгээр улиралд багтаан ИТХ-аар хэлэлцүүлэх.
- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг батлахдаа зураг төсөвгүй ажилд хөрөнгө батлахгүй байх.

Аймгийн Засаг дарга:

- Болзошгүй аваарын зардлаас хөрөнгө зарцуулахад ОБГ, МХГ-ын байцаагчийн дүгнэлтийг үндэслэж байх.
- Төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, зураг төсөвт хяналт тавих чиг үүргийг тодорхой болгох.
- Хөрөнгө оруулалтын ажлыг бөөн дүнгээр бус төсөл арга хэмжээний нэр тус бүрээр задалж, төлөвлөн ИТХ-д өргөн мэдүүлэх
- Барилга байшин барихаар төлөвлөж буй байршилд газрын зөвшөөрлийг олгохдоо барилгын норм ба дүрэм, стандартыг үндэслэн гадна тохижилт, хашаа, хамгаалалтын бүсийг төлөвлөх боломжтой байхаар газрын хэмжээг шийдвэрлэж байх.

Орон нутгийн өмчийн газарт:

- Тухайн ажлын онцлог байдлыг харгалзан үзэж тохиромжтой улиралд ажлыг гүйцэтгүүлэх гэрээ байгуулж байх.
- Жил бүрийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахад ажил бүрт зарцуулсан хоногийн судалгааг нарийвчлан гаргаж, аймгийн Засаг дарга болон ИТХ-д санал хүргүүлж төлөвлөлт хийхэд ажлын онцлог шинжийг харгалзан үзэж тухайн ажлын гүйцэтгэх улирлыг зөв төлөвлөхөд анхаарч ажиллах.

- Жил бүр хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын гүйцэтгэлийн мэдээллийг аж ахуйн нэгж бүрээр авч нэгтгэн мэдээллийн санд оруулж, баяжуулж дараа оны худалдан авах ажиллагааны үйл ажиллагаа, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад ашиглаж байх.

Аймгийн СТСХэлтэст:

- Төсвийн хэмнэлтийн талаар болон Сангийн яамны эрх нээж өгсөнтэй холбоотой тоон үзүүлэлтийг хөтөлж мэдээлэл бэлтгэж, түүнээс гарах үр ашиг, үр дүн, үр нөлөөллийг дүгнэн нэгдсэн санхүүгийн тайлангийн тодруулгад оруулж байх
- Болзошгүй аваарын зардлаас санхүүжүүлэх ТАХ-нд санхүүжилт олгохдоо ОБГ, МХГ-ын байцаагчийн дүгнэлтийг үндэслэж анхан шатны баримтын бүрдлийг бүрэн бүрдүүлсэний дараа олгож байх

Аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэст:

- Томоохон бүтээн байгуулалтын ажилд техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж үр ашгийг тооцсоны дараа төсвийн төсөлд тусгах

Хотын захирагчийн алба, ХББЗА ОНӨҮГ-т:

- Зураг төсөл хийхдээ барилгын онцлог болон дэвшилтэт технологийг тусгаж, үр ашигтай ашиглах боломж бүрдэж байгаа эсэхийг тооцон зурагт бүрэн тусгасан эсэхийг хяналт хэрэгжүүлж байх.
- Захиалагчийг төлөөлөн зураг төсөл гүйцэтгүүлэхээр санал хүргүүлэхдээ техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа, иж бүрэн байдлыг зайлшгүй харгалзан үзэж зураг төслийг боловсруулж байх.
- Томоохон барилга байгууламжийн ажлын төсвийг нэгдсэн нэг төсөв хийж, түүнийгээ тухайн оны төсвийн байдлаас шалтгаалан хэсэгчлэн хувааж, ажил давхцаж орсон эсэхийг тулган шалгаж байх.
- Зураг төсөвт хяналт хэрэгжүүлж, илэрсэн алдааг төсөв батлахаас өмнө засаж залруулах, техник технологийн дэвшил, орчин үеийн шийдлээс үүссэн төсвийн хэмнэлт, хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцон судалгаа гаргаж, холбогдох газрыг мэдээллээр хангах.

ҮАГ санал:

Барилга хот байгуулалтын яамнаас Барилгын хөгжлийн төвөөр дамжуулан барилгын тусгай зөвшөөрөл, Эрчим хүчний яамнаас цахилгаан болон дулааны тусгай зөвшөөрлийг тус тус олгож байна.

Дээрх яамдуудад тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгахдаа гол мэргэжлийн ажилчид байгаа эсэх, тухайн ажигнуудын тогтвор суурьшилын талаар мэдээлэл судалгааг нарийвчлан авч байх талаар зөвлөмж хүргүүлэх саналтай байна.

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ЭРДЭНЭ

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР
ШИНЖЭЭЧ

Б.БАЙГАЛ
Т.БОЛОРМАА

Хавсралт № 01

“Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” гүйцэтгэлийн аудитаар илэрсэн төлбөр зөрчлийн жагсаалт

/ мянган төгрөгөөр/

Актын дугаар	Зөрчлийн товч утга	Төлбөр хариуцагч байгууллага	Төлбөр хариуцагчийн		Төлбөр	Зөрчил
			Албан тушаал	Нэр		
02/25	Жаргалант сумын Жаргалант багийн Бөөн бургаст 104/24/88.3; 49/02/29.8 солбилцол бүхий талбайд тариалан эрхлэгчдийн ундны ус, жимсний талбай услах зориулалтаар шинээр гаргах 1 худаг 14,070,923 төгрөгийн төсөвт өртгөөр хийгдэхээр байтал хийгээгүй	Хөвсгөл Ундарга ХХК	Захирал	А.Дорж	14070.9	
03/26	Оюут багийн 2-8, 2-9, 2-10, 2-11 дүгээр байрны тоглоомын талбай тохижуулах ажлаас 23,672,053 төгрөгийн ажлыг чанаргүй гүйцэтгэсэн байна.	Ээнд-од ХХК	Захирал	Б.Ариунболд	23672.1	
26/29	Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн барилгын ажлын гүйцэтгэлээр нийт 48,771,737 төгрөгийн ажлыг чанаргүй хийсэн байна.	Сэхүүн Чоно ХХК	Захирал	Б.Тэгшбаяр	48771.7	
05/31	Орхон аймгийн тэшүүрийн холбоо нь 4000.0 мянган төгрөгийн хөрөнгийг тоо ширхэг дутуу, иж бүрдэл хангалтгүй, санхүүжилтийн анхан шатны баримтыг хуурамчаар үйлдэн санхүүжилтыг бүрэн авсан нь ашиглал, шамшигдал, завшсан залилангийн шинжтэй үйлдэл хийсэн.	Орхон аймгийн тэшүүрийн холбоо	Дарга	Б.Гантүшиг	4000.0	
10/39	“Жавхлан харгуй” ХХК нь гэрээнд заасан санхүүжилтаа бүрэн авсан боловч чанаргүй гүйцэтгэсэн 63,272,000 төгрөгийн гэрээт ажлыг дахин гүйцэтгэх шаардлагай	Жавхлан харгуй ХХК	Захирал	Д.Мөнх-Очир		63272.0
01/01	“Эрдэнэт секьюрити спэйшл” ХХК Баян-Өндөр сумын багуудыг дохиолол хамгаалалтын системд холбох ажилд багууд дээр байрлуулсан хяналтын дэлгэцүүд бүрэн суурьлагдаагүй, хамгаалалтын хайрцагт байрлуулаагүй, 21 багийг хянах нэгдсэн дэлгэц нь одоогоор ажиллаагүй, хүлээлгэн өгөхдөө туршилт тохируулга хийгүй нийт 73,600.000 төгрөгийн гэрээт ажлыг бүрэн санхүүжилт олгосон байна.	Эрдэнэт секьюрити спэйшл ххк	Захирал	Д.Эрдэнэбат		73550.0
03/03	Нийт 3.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг чанаргүй хийж гүйцэтгэсэн байна.	ДБЧЭ ХХК	Захирал	Я.Энхтуяа		3737.3
09/37	Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн”цогцолборын уран бүтээлийн 373,206,060 төгрөгийн гэрээт ажлыг чанаргүй хийж гүйцэтгэсэн байна.	“Их материал” ХХК	Захирал	Д.Баярмөнх		373206.1
11/46	Өрхийн эрүүл мэндийн цогц төв барих ажлын гүйцэтгэлээс 14,193,718 /арван дөрвөн сая нэг зуун ерэн гурван мянга долоон зуун арван найман төгрөг/ ажил чанаргүй гүйцэтгэсэн байна.	Сэхүүн Чоно ХХК	Захирал	Б.Тэгшбаяр		14193.7
04/04	“Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн” цогцолборын 85.3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн байдал хангалтгүй, бүрэн ашиглалтгүй, 5д кино театрын сандлыг ажиллуулах моторыг байрлуулах газрыг шийдээгүй, тоног төхөөрөмжийг байрлуулахдаа бүрэн суурилуулж шийдвэрлээгүй.	УТООБ ХХК	Захирал	Т.Ариунжаргал		85319.0
	ХББЗА ОНӨҮГ-ийн хяналт хэрэгжүүлэгч ажилтанууд нь барилга байгууламжийн үе шатны ажлыг гүйцэтгэх явцад зураг төсөл, барилгын норм, дүрэм, техникийн нөхцөлийг зөрчиж, чанаргүй болон дутуу гүйцэтгэсэн тохиолдолд түүнийг гүйцэтгэгчийн					

13/54	зардлаар засуулах, нөхөн хийлгэх, санхүүжилтийг зогсоох, учирсан хохирлыг төлүүлэх арга хэмжээ авах ажлын хангалтгүй гүйцэтгэсэн 22 ажлыг гүйцэтгэгч байгууллагаар дахин гүйцэтгүүлж, ажлын чанар үр нөлөөг дээшлүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулж ажиллах шаардлагатай.	ХББЗА ОНӨҮГ	Захирал Ерөнхий инженер	Б.Мөнхдал ай Ц.Хишигжа ргал			
12/53	Орон нутгийн өмчийн газар нь хөрөнгөө санхүүгийн бүртгэлдээ тусгаагүй байгууллагуудад уг хөрөнгийг материалыг хүргүүлэх, бүртгэлд тусгасан эсэхийг хянаж баталгаажуулах ажил хангалтгүй өмнөх аудитаар хүргүүлсэн 2 зөвлөмжийг биелүүлээгүй байна.	Орон нутгийн өмчийн газар	Дарга Өмчийн бүртгэл, хяналт хариуцсан мэргэжилт эн	Л.Оюунгэрэ л Ц.Эрдэнэчи мэг		153319.0	
Нийт дүн						90514.7	766597.1